



САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 9 дүгээр сар

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН – 2022.09

АГУУЛГА

Хураангуй	3
1. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал	8
1.1 Дэлхийн эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал	8
Шигтгээ 1. Евро бүсийн инфляц	10
Шигтгээ 2. Хятадын төв банк бодлогын хүүгээ дараалан бууруулав.	15
1.2 Дэлхийн санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал	16
Шигтгээ 3. АНУ-ын Холбооны нөөцийн сангийн тэргүүний мэдэгдлийн дараа Ази, Номхон далайн улс орнуудын хувьцааны үнэ унаж эхлэв.	20
2. Дотоод эдийн засгийн орчин	21
2.1 Төлбөрийн тэнцэл	21
2.2 Өрх, иргэд	23
2.3 Аж ахуйн нэгж	29
2.4 Улсын төсөв	34
Шигтгээ 4. Эрсдэлийн зураглал	36
3. Санхүүгийн салбарын нөхцөл байдал	38
3.1 Банкны салбарын нөхцөл байдал	38
Шигтгээ 5. Монголбанк Активын чанарын үнэлгээг гүйцэтгэж байна.	41
Шигтгээ 6. Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн	45
Шигтгээ 7. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түүвэр судалгаа	49
3.2 Банкны бус санхүүгийн салбарын нөхцөл байдал	51
Шигтгээ 8. Эдийн засгийн өсөлтийн эрсдэлийн шинжилгээ	59
4. Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн	60
4.1 Банкны салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	60
4.2 Банкны бус санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	66

Хураангуй

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 16 дахь дугаарыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран боловсруулж, олон нийтэд хүргэхэд бэлэн болгоод байна. Уг тайлан нь 1) Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал; 2) Монгол Улсын эдийн засгийн дотоод орчин; 3) Санхүүгийн салбарын нөхцөл байдал; 4) Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэрэг нийт 4 бүлгээс бүрдэж байна.

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал

Орос-Украины дайн, үүнээс үүдэлтэй худалдааны хориг арга хэмжээнүүд нь дэлхийн эрчим хүч, хүнс болон түүхий эдийн зах зээлд сөрөг шокууд бий болгон, улмаар дэлхийн улс орнуудад инфляцийн түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжлийг сааруулах зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Цаашид Орос-Украины дайн болон Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нийлүүлэлтийн сүлжээн дэх тасалдал үргэлжилсэн тохиолдолд дэлхийн улс орнуудад инфляцийн өндөр түвшин илүү урт хугацаанд хадгалагдах, эдийн засгийн хүндрэл үүсгэх зэрэг эрсдэлийг дагуулж байна. Ийнхүү эдийн засаг, геополитикийн тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбогдуулан 2022 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид энэ оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 1.2 нэгж хувиар бууруулж, 3.2 хувь байхаар шинэчлэн тооцлоо.

Дэлхийн зах зээл дээрх эрчим хүчний түлш болох байгалийн хий, газрын тос, нүүрс болон эрчим хүчний хэрэглээний үнэ 2021 оноос эрчимтэй өслөө. Үүнд нэг талаас дэлхийн эдийн засаг идэвхжлийг дагаж эрчим хүчний түлшний эрэлт хурдацтай нэмэгдсэн нь нөлөөлөв. Нөгөө талаас нефть экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК)-ын гишүүн орнуудын үйлдвэрлэлийн хязгаарлалт болон Орос-Украины дайн, үүнээс үүдэлтэй хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан нийлүүлэлтийн хомсдол үүссэн нь нөлөөллөө. Цаашид эрчим хүчний үнийн дарамт богино, дунд хугацаанд хадгалагдах төлөвтэй байна.

Дэлхийн санхүүгийн нөхцөл сүүлийн жил гаруй хугацаанд тасралтгүй чангарсаар байна. Үүнд хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнэ буурч, хөгжингүй болон хөгжиж буй орнуудад инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүгээ нэмэгдүүлж, Засгийн газрын бондуудын өгөөж өссөн зэрэг нь голлон нөлөөлөв. Хөгжингүй орнуудын төв банкууд мөнгөний бодлогын төлөвөө үргэлжлүүлэн чангаруулвал Засгийн газрын бондуудын өгөөж өсч санхүүгийн нөхцөл улам чангарах, цаашлаад хөгжиж буй орнуудаас гадагшлах хөрөнгийн урсгал тэлж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Ялангуяа санхүүгийн нөхцөл глобал орчинд ийнхүү чангарах нь хөгжиж буй орнуудын эдийн засагт томоохон сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй юм.

Эрдэс бүтээгдэхүүний экспортод суурилсан жижиг нээлттэй эдийн засагтай, түүнчлэн гадаад өр, зээлийн дахин санхүүжилт хийх хэрэгцээ, шаардлага өндөр Монгол Улсын хувьд дэлхийн эдийн

засаг, санхүүгийн зах зээлийн орчинд гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь дотоодын эдийн засагт бодит эрсдэлүүдийг учруулж байна. Тухайлбал, (i) ОХУ-Украины дайны нөхцөл байдал, хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан Монгол Улсын гадаад худалдаа, нефтийн бүтээгдэхүүний импортод сөргөөр нөлөөлөх, (ii) дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын идэвхжилийн сааралтыг даган эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах, (iii) Санхүүгийн нөхцлийн чангаралтын улмаас хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэх, улмаар зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж, гадаад санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлэх зэрэг гадаад орчны эрсдэлүүд өндөр байна.

Дотоод эдийн засгийн орчин

Монгол Улсын экспортын голлох эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ өсч, худалдааны нөхцөл эрс сайжирсан боловч БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтууд хэсэгчлэн болон бүрэн хаагдсанаар экспортын биет хэмжээний өсөлт удааширч, барааны импортын зардал огцом өсч, улмаар урсгал тэнцлийн алдагдал ихээхэн тэлэв. Хэдийгээр хөрөнгийн дотогшлох урсгал сайжирч, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн ч урсгал тэнцлийн томоохон алдагдлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байсан тул төлбөрийн тэнцэл 2022 оны эхний хагаст 1058.0 сая ам.долларын алдагдалтай гарав. Ийнхүү төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн нь төгрөгийн ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж, улмаар ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор хийгдсэн Монголбанкны интервенцийн үр дүнд гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн хэмжээ буурч, 2022 оны 6 дугаар сарын эцэст 3097.0 сая ам.долларт хүрэв.

Цар тахлын дараах эдийн засгаа сэргээх зээлийн төлөвлөгөөний хүрээнд банкуудын зээл олголт тэлж, иргэдийн хэрэглээний болон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл огцом нэмэгдэв. Түүнчлэн банк бүс санхүүгийн байгууллагууд дахь иргэдийн зээлийн хэмжээ 2022 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 62.6 хувиар өсөж, зээлийн үлдэгдэл 2.4 их наяд төгрөгт хүрчээ. Хөдөлмөрийн зах сэргэж, өрхийн бодит орлого нэмэгдсэн хэдий ч санхүүгийн салбар дахь иргэдийн зээлийн хэмжээ ийнхүү огцом өсөж өрхийн өрийн хэмжээ нэмэгдсэн нь цаашид өрхийн секторт эмзэг байдал үүсч болзошгүй байна. Түүнчлэн, цар тахлын үеийн зээлдэгчдэд чиглэсэн хөнгөлөлтийн арга хэмжээ, зохицуулалтууд дуусгавар болсноор иргэдийн зээлийн эргэн төлөлт доголдох, зээлийн чанар муудаж болзошгүй байна.

Төрөөс хэрэгжүүлж буй эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн нөлөөгөөр үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоох аж ахуйн нэгжүүдийн тоо буурч байна. Тодруулбал, 2022 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар өнгөрсөн жилийн мөн үеэс хойш 130 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон бол цар тахлын үед буюу 2021 оны 1 дүгээр улирлын эцэст 2136 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоож байв. Гэвч үйл ажиллагаагаа зогсоож буй аж ахуйн нэгжийн тоо нь шинээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тооноос давж байна.

Өндөр инфляц, гадаад эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зардал өсөж, ашигт ажиллагаа, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн хувийн секторт олгосон зээлийн салбараарх төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлээ. Үүнээс зарим салбаруудад гадна аж ахуй

нэгжүүдийн үйл ажиллагааны сэргэлт удаашралтай байгаа нь борлуулалтын орлого буурах, зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтээс шалтгаалан төсвийн тэнцэл сайжирч байгаа ч төсвийн хуримтлагдсан алдагдал өндөр хэвээр байна. Төсвийн орлого бүрдэлтэд нэг талаас дэлхийн геополитикийн асуудал, худалдааны хориг арга хэмжээнүүдээс үүдэлтэй уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, нөгөө талаас БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтуудад үүсч буй саатлаас шалтгаалсан экспорт, импортын биет хэмжээнд гарч буй өөрчлөлтүүд голлон нөлөөлж байна.

Монгол улсын гадаад өрийн дарамт өндөр хэвээр байна. Монгол Улсын нийт гадаад өр 2022 оны эхний улирлын байдлаар 33.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсөв. Санхүүгийн нөхцөл глобал орчинд чангарч байгаа нь ирэх онуудад Засгийн газрын болон Засгийн газрын баталгаатай гадаад бонд, зээлийн төлбөрийг дахин санхүүжүүлэх тохиолдолд санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг тодорхой эрсдэлүүдийг учруулж болзошгүй юм.

Санхүүгийн салбарын нөхцөл байдал

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний хагаст 23.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өслөө. Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн эерэг нөлөөгөөр банкуудын зээл олголт нэмэгдэж, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт агшсанаар банкны системийн зээлийн багцын нийт активт эзлэх хувь хэмжээ өсөж байна. Энэхүү өөрчлөлтөөс шалтгаалан өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа бага зэрэг муудаж, банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ буурсан үр дүн гарав.

Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлд Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 4.8 их наяд төгрөгийн дүнтэй 134,752 зээл Ковид-19-д өртсөн байгаагаас 71 хувь буюу 3.46 их наяд төгрөгийн 105,693 зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөх нөхцөлд өөрчлөлт оруулаад байна.

Банкуудад байршуулсан хугацаагүй хадгаламж, харилцахад хүү төлөхгүй байх хуулийн зохицуулалт үргэлж байгаатай холбоотойгоор банкны хүүгийн зардал өмнөх оноос буурсан бол хүүгийн бус орлогын хэмжээ нэмэгдэж, улмаар банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирлаа.

Гадаад орчны таагүй байдал, төлбөрийн тэнцлийн өндөр алдагдлын улмаас ханшийн сулрах дарамт нэмэгдэж байгаа нь банкны салбарын эх үүсвэрийн долларжилтыг өдөөж, банкуудын гадаад валютын позицод сөргөөр нөлөөлж байна.

Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүдээс харахад 2022 оны 6 дугаар сарын байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, нийт

өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс өндөр байв.

Банк бус санхүүгийн салбарын хувьд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өсжээ. Гэвч нийт үнэт цаасны арилжааны дүн агшиж, өмнөх оны мөн үеэс 2.3 дахин буурсан дүнтэй байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 431.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 48.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс 66.1 хувиар өссөн дүн боллоо.

ББСБ-уудын нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар, нийт зээлийн хэмжээ 58.9 хувиар тус тус өссөн бол ХЗХ-дын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар, нийт зээлийн хэмжээ 16.6 хувиар тус тус өсчээ.

Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монголбанкнаас санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлж, зээлийн тасалдлаас сэргийлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлд бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэн бууруулж, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн 2021 оны түршид хэвээр хадгалав. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд зээлийн өсөлт сэргэж, бодит секторыг шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээр хангаж, эдийн засгийн сэргэлтэд эерэгээр нөлөөлөв. Цар тахал эхэлснээс хойшхи 2 жил гаруйн хугацаанд Төв банкнаас авч хэрэгжүүлсэн санхүүгийн зохицуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн арга хэмжээнүүдийг дуусгавар болгов.

Цар тахалтай холбоотойгоор зээлдэгчдэд үүсэж буй дарамтыг бууруулах зорилгоор цогц бодлогын арга хэмжээнүүдийг Монголбанкнаас авч хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг буурууллаа.

Харин 2022 оны эхнээс олон улсын харилцаанд хурцадмал байдал шинээр үүсэж, гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдал огцом нэмэгдсэн нь инфляцийг өсгөж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Ийнхүү эдийн засгийн өсөлт саарсан, инфляц нэмэгдсэн, төгрөгийн ханш сулрах дарамт өндөр байгаа нөхцөлд мөнгөний тэлэх бодлогоор эдийн засгийн сэргэлтийг дэмжих орон зай хязгаарлагдсан тул 2022 оны 1 дүгээр сараас эхлэн бодлогын хүүг шат дараатайгаар нэмэгдүүлж 10 хувьд хүргээд байна. Түүчнлэн төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацаат репо арилжааны санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх шийдвэр гаргав.

Цар тахал эхэлснээс хойшхи 2 жил гаруйн хугацаанд Төв банкнаас авч хэрэгжүүлсэн санхүүгийн зохицуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн арга хэмжээнүүдийг дуусгавар болгов.

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллөөс шалтгаалан санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах чиглэлд СЗХ-ноос “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020-2021 онд нийт 3 удаа өөрчлөлт оруулж, зээлийн ангиллын хугацаанд өөрчлөлт оруулав. 2022 оны 1 дүгээр сард СЗХ-ны ээлжит хуралдаанаар холбогдох журамд дахин өөрчлөлт оруулан, актив ангиллын хугацааг үе шаттайгаар буюу 30 хоногоор бууруулаад байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсантай холбогдуулан СЗХ-ноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх үйл ажиллагааг 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлж, холбогдох журам зааврыг боловсуурлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

1. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал

1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ


Дэлхийн геополитикийн асуудлаас шалтгаалан тодорхойгүй байдал нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширч, цаашдын төлөв муудав. Ковид-19 цар тахлын хязгаарлалтууд суларч, эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээс шалтгаалан 2021 онд дэлхийн эдийн засаг огцом сэргэж, 6.1 хувиар өсөв. Гэвч Украин дахь дайн эхэлснээс хойш буюу 2022 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2022 оны 1 дүгээр сарын төсөөллөөс 1.2 нэгж хувиар бууруулж, 3.2 хувь байхаар тооцсон бол Евро бүс, АНУ, БНХАУ-ын өсөлтийн төсөөллийг 1.3, 1.7, 1.5 нэгж хувиар тус тус бууруулж, 2.6, 2.3, 3.3 хувь болголоо (Зураг 1.1, 1.2).

Тус геополитикийн хурцадмал байдал нь дэлхийн худалдаа, түүхий эд, санхүүгийн зах зээлд шокууд бий болгож, дэлхийн эдийн засагт сэргөөр нөлөөлж байна. Түүнчлэн энэхүү хурцадмал байдал бий болохоос өмнө буюу 2021 онд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын инфляцын түвшин эрчимтэй өсч, улмаар Төв банкууд мөнгөний бодлогоо чангаруулаад байсан нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд сэргөөр нөлөөлөөд байв.

Олон улсын хэмжээнд инфляц өмнөх таамаглалаас давж, үнийн дарамт нэмэгдсээр байна. Тухайлбал, 2021 оны сүүлээр цар тахлын дараах эдийн засгийн идэвхжил, нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалан


хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад инфляц эрчимтэй нэмэгдсэнээр ихэнх Төв банкууд мөнгөний бодлогоо чангаруулж, бодлогын хүүгээ нэмэгдүүлж байв (Зураг 1.3). Улмаар 2022 оны 2 дугаар сард эхэлсэн Украин дахь дайн нь дэлхийн зах зээл дээрх эрчим хүч, түүхий эд, хүнсний үнийн шокууд бий болгосноор улс орнуудын инфляцын түвшин үргэлжлэн өслөө.

Зураг 1.1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Зураг 1.2. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийн өөрчлөлт



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний саатал дэлхийн эдийн засгийн өсөлтөд саад болж, инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

Тухайлбал, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний дарамтын индекс (GSCPI) цар тахлын нөлөөгөөр 2020-21 онд, Украин дахь дайны нөлөөгөөр 2022 оны эхээр огцом өссөн ба өндөр хэвээр байна (Зураг 1.4). Түүнчлэн дэлхийн томоохон аж үйлдвэрүүд ОХУ, Украины түүхий эдээс өндөр хамааралтай учир дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд цаашид тасалдал үүсэх эрсдэлтэй байна.

ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнүүдтэй холбоотойгоор байгалийн хий, нефтийн бүтээгдэхүүний үнэ өсч улс орнуудад эрчим хүчний инфляцыг өдөөсөн бол Украины үр тариа, хүнсний экспортын бэрхшээлээс шалтгаалан бага орлоготой импортлогч орнуудад хүнсний хомсдол, инфляцын дарамт ихээхэн нэмэгдэв.


Эрчим хүчний түлш болох байгалийн хий, газрын тос, нүүрс болон эрчим хүчний хэрэглээний үнэ 2021 оноос эрчимтэй өсөв.

Дэлхийн эдийн засаг идэвхжсэнээр газрын тосны эрэлт хурдацтай сэргэж, нөгөө талдаа ОПЕК-ын гишүүн орнуудын үйлдвэрлэлийн хязгаарлалт, Украин дахь дайн, улс орнуудаас ОХУ-ын газрын тосны импортод тавьсан хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан нийлүүлэлт хумигдсанаар үнэ эрчимтэй өсч 2022 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 64.3 хувиар нэмэгдэж, 120 ам.долларт хүрэв. Цаашид газрын тосны үнийн дарамт богино, дунд хугацаанд хадгалагдахаар байна (Зураг 1.5).

Цар тахлын дараах дэлхийн эдийн засгийн идэвхжил, Европын орнуудын ОХУ-аас импортолдог байгалийн хийн хамаарлаа бууруулах зорилт болон 2021 оноос эхлэн


Европын орнууд дахь хэрэглээний нөөц эрс багассан зэрэг шалтгаанаар дэлхийн зах зээл дээрх байгалийн хийн үнэ сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрч өсөв.

Зураг 1.3. Инфляцын түвшин, төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Зураг 1.4. Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний дарамтын индекс



Эх сурвалж: Нью-Йорк Холбооны Нөөцийн Банк, GSCPI index

Зураг 1.5. Байгалийн хий, газрын тос, нүүрсний үнэ




Эх сурвалж: Блүүмберг

Шигтгээ 1. Евро бүсийн инфляц

Европын холбооны статистикийн байгууллагын мэдэгдэж байгаагаар Евробүсийн инфляц 2022 оны 8 дугаар сард жилийн 9.1 хувьд хүрсэн ажээ. 7 дугаар сараас хойш хүнс, согтууруулах ундаа, тамхи, эрчим хүчний бус аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ үргэлжлэн өссөн байна. Эрчим хүчний инфляц 7 дугаар сард жилийн 39.6 хувиар өссөн бол 8 дугаар сард жилийн 38.3 хувь болсон байна. Орос-Украины дайны нөхцөл байдал Евробүсийн эрчим хүч, хүнсний үнэ, улмаар инфляцад нөлөөлж цар тахлын дараа хүлээгдэж байсан эдийн засгийн сэргэлтийг боомилж магадгүй болоод байна. Оросын инфляц 7 дугаар сард жилийн 15.1 хувьд хүрсэн нь 5 дугаар сарын жилийн 17.1 хувиас буурсан үзүүлэлт ажээ.

Зураг 1.6. Европын орнуудын инфляц



Эх сурвалж: Trading Economics, Eurostat

Европын Төв банк сүүлийн 11 жилд анх удаа бодлогын хүүгээ хүлээгдэж байснаас илүү хувь хэмжээгээр нэмэгдүүлэн инфляцтай тэмцэж байна. Төв банкны 7 дугаар сарын 21-ний шийдвэр нь хүнс, шатахуун болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг хазаарлах зорилготой ч зээлийг илүү үнэтэй болгосноор евро бүсийн эдийн засгийг хямрал рүү оруулах болгоомжлолыг төрүүлээд байна. Энэ оны 9 дүгээр сард Төв банкнаас бодлогын хүүгээ дахин өсгөхөөр хүлээгдэж байгаа аж.

Орос-Украины мөргөлдөөн эхлэхээс өмнө Евробүс эрчим хүчний үнийн өсөлттэй нүүр тулсан билээ. Дайн эхэлснээр Оросын нефть, байгалийн хийн нийлүүлэлт тасалдаж болзошгүй гэх болгоомжлол газар авсанаар эрчим хүчний хямрал улам даамжрав. ОХУ нь саяхныг хүртэл Европын холбооны нефть, байгалийн хий, нүүрсний томоохон нийлүүлэгч байсан бөгөөд Европын эрчим хүчний хэрэгцээний 1/3-ийг дангаараа хангаж ирсэн билээ. Европын холбоо нь Оросоос авдаг нүүрсний нийлүүлэлтэд 8 дугаар сард хориг тавьсан бол байгалийн хийн импортыг энэ ондоо багтаан 2/3-оор бууруулахаар төлөвлөөд байна.

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хөл хориог 2020 оноос олон оронд нэвтрүүлж эхэлснээр дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд доголдол үүсч, хураасан ургацыг борлуулах боломжгүй болж, олон бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэр дундаа хүнсний үнэ өсч, иргэд сандралд автан дэлгүүрийн лангууг хоослох үзэгдэл газар авсан билээ. Гэтэл Орос-Украины хооронд цэргийн мөргөлдөөн гарснаар тус нөхцөл байдал улам даамжирсан байна. Учир нь дээрх хоёр улс дэлхийн улаан буудай, арвайн 1/3-ийг, наранцэцгийн тосны 2/3-ыг хангадаг ажээ. Украин эрдэнэ шишийн экспортоор дэлхийд дөрөвт жагсдаг байна.

Эх сурвалж: Европын Төв банк, Европын холбооны статистикийн байгууллага (Eurostat)

Түүнчлэн, тээвэр логиستيкийн асуудал, засвар үйлчилгээ, цаг агаар, сэргээгдэх эрчим хүчний бодлого зэрэг үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалан дэлхийн нүүрсний үйлдвэрлэл буурсан бол нөгөө талдаа аж үйлдвэрлэлийн идэвхжил, улс орнуудын ОХУ-ын нүүрсний импортоос татгалзах бодлого, эрчим хүчний үйлдвэрлэлд байгалийн хийг орлуулах болсноос үүдэн нүүрсний үнэ 2022 он гарснаас хойш өндөр түвшинд хадгалагдаж, цаашид үнийн дарамт хэвээр байх төлөвтэй байна.

Олон улсын хэмжээнд өндөр инфляц өмнөх төсөөллөөс урт хугацаанд хадгалагдахаар байна. Украины дайны цар хүрээ, үр дагавар өргөжиж, үнийн дарамт улс орнуудад нэмэгдэж буй нь олон улсын хэмжээнд өндөр инфляцын түвшин илүү урт хугацаанд хадгалагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Украины дайн эхэлсний дараа буюу 2022 оны 4 дүгээр сард ОУВС-гийн шинжээчид 2022 оны хөгжингүй болон хөгжиж буй орнуудын инфляцын төсөөллийг 2022 оны 1 дүгээр сарын төсөөллөөс 1.8 болон 2.8 нэгж хувиар тус тус нэмж, 5.7 болон 8.7 хувь болгосон байна (Зураг 1.7).

Дэлхийн аж үйлдвэрлэл болон худалдааны сэргэлт удаашрав. Дэлхийн аж үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд огцом сэргэж 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өсч байсан бол үүнээс хойш өсөлт эрчимтэй буурч 2022 оны 4 дүгээр сарын байдлаар 1.2 хувьд хүрээд байна (Зураг 1.8). ОУВС-гийн дүгнэлтээр Украин дахь дайн, Төв банкуудаас инфляцын эсрэг авч хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого, Ковид-19 цар тахлын хязгаарлалтын үр дагавар, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв муудаж, улс орнуудын төсвийн бодлогын орон зай хумигдсан зэрэг нь

дэлхийн аж үйлдвэрлэл, эдийн засгийн идэвхжил буурах үндсэн шалтгаан болж байна.

Зураг 1.7. Инфляцын төсөөллийн өөрчлөлт



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Зураг 1.8. Дэлхийн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, худалдааны хэмжээний жилийн өөрчлөлт



Эх сурвалж: CPB Нидерланд улсын эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо, 2022 оны 4 дүгээр сарын байдлаар.

Аж үйлдвэрлэлийн үзүүлэлтийн адилаар дэлхийн худалдааны хэмжээ 2020 оны дунд үеэс идэвхжиж, 2021 оны 4 дүгээр сард түүхэн дээд түвшинд буюу өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн бол үүнээс хойш өсөлт удааширч, 2022 оны 4 дүгээр сарын байдлаар 3.1 хувьд хүрч буураад байна. (Зураг 1.8) Үүнд Азийн бүс нутаг дахь Ковид-19 цар тахлын хязгаарлалтаас шалтгаалсан нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, цар тахлын үеийн эдийн засгийн дэмжлэгүүд дуусгавар болсон, геополитикийн хурцадмал байдал,

үүнээс шалтгаалсан худалдааны хориг арга хэмжээнүүд зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байна. Дэлхийн банк, ОУВС-гийн төсөөллөөр эдийн засгийн идэвхжил суларч байгаагаас үүдэн дэлхийн худалдааны өсөлт 2022 онд 4.0-5.0 хувь, 2023 онд 4.1-4.4 хувь байхаар байна.


Дэлхийн зах зээл дээрх металл, түүхий эдийн үнэ хурдацтай өсч, манай улсын экспортын орлогод дэмжлэг үзүүлээ. Түүхэн дээд түвшинд хүрээд байсан суурь металлуудын¹ үнийн индекс 2021 оны сүүлийн хагаст БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн хязгаарлалт, барилгын салбарын өсөлт удааширсантай холбоотойгоор түр хугацаанд буурав. Гангийн үйлдвэрлэлийн энэхүү хязгаарлалт дүүсгавар болж, цахилгаан машины үйлдвэрлэл, Украины дайнтай холбогдох хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан суурь металлуудын үнэ 12 дугаар сараас хойш эргэн өсч, өндөр түвшинд хадгалагдаж байна (Зураг 1.9).

ОУВС-гийн тооцооллоор аж үйлдвэрлэл, барилгын салбарт ихээхэн ашиглагддаг зэс, төмрийн хүдрийн нийлүүлэлтэд ОХУ-ын худалдааны тасалдал, эрчим хүчний өсч буй зардал нөлөөлснөөр үнийн дарамт үргэлжилж, суурь металлын үнэ 2022 онд дунджаар 9.9 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Харин 2023 онд үнэ тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна. Тухайлбал, энэ онд 1 тонн зэсийн үнэ 10100 ам.доллар, 1 тонн төмрийн хүдрийн үнэ 140 ам.долларын орчимд байхаар байна.

Дэлхийн банкны төсөөллөөр нэг унц алтны үнэ энэ оны сүүл хагаст 1880 ам.долларын

орчимд хэлбэлзэхээр байна. Олон улсын хэмжээнд инфляцын түвшин эрчимтэй өсч, геополитикийн хурцадмал байдал нэмэгдэж буй нь алтны үнэ өндөр байхад нөлөөлж байна. ОХУ нь дэлхийн хоёр дахь томоохон алт олборлогч улс бөгөөд дэлхийн нийт үйлдвэрлэлийн 10 орчим хувийг бүрдүүлдэг байна (Зураг 1.10).


Зураг 1.9. Зэс, нүүрс, төмрийн хүдэр, Brent нефтийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: Нүүрсний үнийн хувьд МУ-ын экспортын нүүрсний дундаж үнэ болно. Бусад үзүүлэлтүүдийн үнийн төсөөллийг Блүүмбергийн жигнэсэн дунджийг ашиглав.

Зураг 1.10. Алтны үнэ



Эх сурвалж: Блүүмберг

Жижиг нээлттэй эдийн засагтай Монгол Улсын хувьд металл, түүхий эдийн экспорт, хүнс, шатахууны импортын өндөр хамаарлаас шалтгаалан глобал макро эдийн засагт гарч

¹ Зэс, төмрийн хүдэр, хөнгөн цагаан, никель зэрэг аж үйлдвэрлэл, барилгын салбарт ашиглагддаг металл.

буй өөрчлөлтүүд нь дотоодын эдийн засагт ихээхэн сөрөг үр дагавар, эрсдэлийг бий болгож байна. Ялангуяа дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн богино хугацааны савалгаа, цар тахал болон геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан экспорт импортын тасалдал, хүлээлт, глобал инфляц, шатахууны үнийн өсөлтийн нөлөө зэрэг нь Монгол Улсын эдийн засагт томоохон эрсдэл, эмзэг байдлыг бий болгож байна.

Ковид-19 цар тахал хумигдаж, дэлхийн эдийн засаг хурдацтай сэргэж эхэлсэн хэдий ч цар тахлын вирусын шинэ вариантууд гарч, геополитикийн зөрчил хурцдаж буй нь эрсдэл, эмзэг байдлыг нэмэгдүүлж, сэргэлтийг удаашруулж байна. Дэлхий даяар цар тахлын шинэ тохиолдлын тоо буурч, улс орнууд хязгаарлалтуудаа суллаж байгаа ч вирус дахин сэргэх, ирээдүйд эдийн засгийн үйл ажиллагаанд саад учруулах магадлал өндөр хэвээр байна. Ялангуяа Азийн орнуудад цар тахлын шинэ давалгаанууд гарч, хөл хорио, хязгаарлалтуудаа илүү чангатгаж, БНХАУ нь тэг ковид бодлогоо үргэлжлүүлж байгаа нь дэлхийн болон бүс нутгийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүд төлбөрийн хүндрэлд орсон тул зохицуулагч байгууллагуудын зүгээс зээлийн хугацааг сунгаж, өр төлбөрийг хойшлуулах арга хэмжээг өргөнөөр хэрэгжүүлсэн. Гэвч эдгээр арга хэмжээ хэрэгжиж дуусахад аж ахуйн нэгжүүдийн өрийн түвшин нэмэгдэж, эргээд төлбөрийн хүндрэлд орох, цаашлаад банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Дэлхийн ихэнх улс орнуудад инфляц нэмэгдэж байгаа нь бодлогын орон зайг хязгаарлаж байна. Геополитикийн хурцадмал байдал даамжирч, эдийн засгийн хориг арга хэмжээнүүд өргөжиж байгаагаас шалтгаалан улс орнууд, олон улсын байгууллагууд ирэх онуудын инфляцын төсөөллөө нэмэгдүүлж, инфляцын өсөлт нь хүлээлтээс өндөр байна. Улмаар Төв банкууд мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэх нь Засгийн газрын бондуудын өгөөж өсч санхүүгийн нөхцөл чангарах, цаашлаад хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах урсгал нэмэгдэж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Ялангуяа санхүүгийн нөхцөл глобал орчинд ийнхүү чангарах нь хөгжиж буй орнуудын эдийн засагт томоохон цохилт өгөх юм.


Түүнчлэн, хямралын дараа дэлхийн худалдаа эрчимтэй сэргэж байгаа ба нөгөө талдаа Украин дахь дайн, холбогдох хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал, удаашрал бий болж байна. Энэ нь цаашлаад нийлүүлэлтийн шалтгаантайгаар инфляц нэмэгдэх нөлөөг үзүүлж болзошгүй юм.

Дэлхийн улс орнуудад бодлогын зохицуулалтыг хэрхэн үргэлжлүүлэх нь чухал сорилт болж байна. Цар тахлын дараах дэлхийн эдийн засгийн идэвхжил, тэнцвэрт бус байдлаас шалтгаалсан инфляцын өндөр түвшин нь улс орнуудын Төв банкууд мөнгөний бодлогоо эрчимтэй чангаруулах нөхцөлийг бүрдүүлэв (Зураг 1.11).

Нөгөө талдаа геополитикийн асуудлаас үүдэн тодорхойгүй байдал, макро эрсдэл нэмэгдэж байгаа нь зохицуулагч байгууллагуудад бодлогын сорилтыг бий болгож байна. Иймд цар тахал болон хөнгөлөлттэй зохицуулалтууд дуусч байгаатай холбоотой хуримтлагдсан

эрсдэлийг үнэлж, геополитикийн хурцадмал байдал болон хориг арга хэмжээнүүдийн цаашдын сөрөг нөлөөг харгалзан үзэж, макро эдийн засгийн бодлогоо тохируулан хэрэгжүүлэх нь чухал болж байна.

Зураг 1.11. Зарим орнуудын бодлогын хүүний динамик



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: Сүүлийн хугацаа 2022.06 сар

Шигтгээ 2. Хятадын төв банк бодлогын хүүгээ бууруулав

2022 оны 8 дугаар сарын 15-нд Хятадын төв банк дунд хугацааны зээлийн хэрэгсэл (MLF)-ийн жилийн хүү 2.85 хувь байсныг 0.1 нэгж хувиар бууруулж 2.75 хувь, урвуу репо хэлцлийн хүү 2.1 хувь байсныг 2.0 хувь болгон бууруулснаа зарлав. Энэ нь Хятадын төв банкнаас бодлогын хүүгээ хоёр дахь удаагаа бууруулсан явдал болов. 2022 оны 1 дүгээр сард Хятадын Ардын банк тус хоёр хүүний түвшинг 0.1 нэгж хувиар бууруулж байсан билээ.

Хятадын Ардын банк хугацаа нь 8 дугаар сарын 16-нд дуусч байсан дунд хугацааны зээлийн хэрэгслээр (MLF) нийлүүлсэн 600 тэрбум юаний 200 тэрбумыг нь эргэн татаж, 400 тэрбум юаний хугацааг нь дахин сунгангаа хүүг нь ийнхүү бууруулжээ. Харин 7 хоногийн хугацаатай урвуу репо хэлцлээр 2 тэрбум юанийг зах зээлд нийлүүлсэн байна.

Хятадын Ардын банк тус шийдвэрээ “банкны системийн хөрвөх чадварыг хангалттай түвшинд дэмжих” шаардлагаар тайлбарласан байна. Хятадын эрх баригчид цар тахлаас үүдэн хохирол амссан эдийн засгаа дэмжин, зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд тус шийдвэрийг гаргалаа хэмээн шинжээчид үзэж байна.

2022 оны 7 дугаар сард банкуудаас олгосон зээлийн хэмжээ хүлээгдэж байснаас бага байв. Ковид-19 цар тахал Хятадын зарим хот, бүс нутагт дахин дэгдсэн, ажил эрхлэлтийн тодорхойгүй байдал, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд нүүрлэсэн хямрал гүнзгийрч эхэлснээр иргэд, ААН-ийн зээл авах сонирхол буурсан ажээ.

Bloomberg агентлаг хүүг ийнхүү бууруулсан нь гэнэтийн явдал болсныг онцлоод Хятадын ардын банкнаас эрэлт дорвитой өсөөгүй ч инфляц хурдсах эрсдэл байна хэмээн саяхан мэдэгдэж байсныг сануулжээ.

Хятадын Статистикийн үндэсний хорооноос мэдээлж байгаагаар энэ оны 7 дугаар сард аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн нь 6 дугаар сарын 3.9 хувь, эдийн засагчдын таамаглаж байсан 4.3 хувиас доогуур байсан ажээ.

Хятадын Ардын банк 8 дугаар сарын 22-нд хүүг бууруулах арга хэмжээг үргэлжлүүлэн авч 5 жилийн хугацаатай зээл (LPR)-ийн анхдагч хүү 4.45 хувь байсныг 4.30 хувь, 1 жилийн хугацаатай зээлийн анхдагч хүү 3.70 хувь байсныг 3.65 хувь болгон тус тус бууруулснаа мэдэгдэв. 2019 онд хүүний реформыг гүйцэтгэснээр Хятадын ихэнхи шинэ зээлийн хүү 1 жилийн хугацаатай зээл (LPR)-ийн анхдагч хүүнд суурилдаг болсон ажээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар Хятадын Ардын банк LPR хүүг бууруулсан нь нэгд, MLF хүүг бууруулсны эерэг нөлөө хангалтгүй байгаа, хоёрт, Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд ноцтой асуудал үүссэнтэй холбоотой ажээ. Нөгөө талаас, шинжээчид Хятадын төв банк цаашид ч мөнгөний бодлогодоо шаардлагатай тохиргоо хийгээд явна гэж үзэж байна. Тухайлбал, төв болон орон нутгийн засаг захиргааны зүгээс үл хөдлөх хөрөнгийн зах зээлээ дэмжихэд 3 их наяд юань нийлүүлэх боломжтой.

Хэрвээ Ковид-19 цар тахлын нөлөө эдийн засагт нөлөөлсөн хэвээр байх аваас Хятадын ардын банк 2023 онд бодлогын хүүнүүдээ 0.5 нэгж хувиар буулгах боломжтой хэмээн Хятадын Төв банкны зөвлөх асан Ли Даокуй хэлэв. Түүний үзэж байгаагаар дэлхийн хөгжингүй орнуудын төв банкууд бодлогын хүүгээ өсгөж байхад Хятад бууруулах боломжтой байгаа нь Хятад болон АНУ-ын санхүүгийн систем хооронд “тодорхой хэмжээний тусгаарлалт” байгаатай холбоотой аж.

Эх сурвалж: Хятадын Ардын банк, Хятадын Статистикийн үндэсний хороо, Bloomberg

1.2 ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Хөгжингүй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудад дэлхийн санхүүгийн нөхцөл мэдэгдэхүйц чангарч байна.


Санхүүгийн тогтвортой байдлын эрсдэл олон талбарт өсөж, Евро бүс, АНУ болон хөгжиж буй орнуудын санхүүгийн нөхцөл 2021 оны эхнээс 2022 оны эхний хагас жил хүртэл тасралтгүй чангарсаар байна. Үүнд, компаниудын үнэлгээ буурч, засгийн газруудын бондын өгөөж өссөн нь голчлон нөлөөлөв. АНУ, Евро бүс дэх хөгжингүй орнуудын санхүүгийн нөхцөл энэ жил онцгой чангарсан ч түүхэн дэх хамгийн өндөр түвшинтэйгээ харьцуулахад хэвийн байна.

Мөн Украинд болж буй дайны үр дүнд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг бууруулах эрсдэл үүсэв. Ялангуяа, ОХУ-тай ойрхон зүүн европ болон ойрх дорнодын орнууд дахь өмч хөрөнгийн үнэлгээ буурч, гадаад зээлийн зардал, банкуудын эх үүсвэрийн зардал өссөн нь санхүүгийн нөхцөл чангарахад нөлөөлж байна.

Түүнчлэн бусад олон хөгжиж буй улсуудад инфляцтай тэмцэх зорилгоор бодлогын хүүг өсгөсөн нь санхүүгийн нөхцөл чангарахад нөлөөллөө.

Харин БНХАУ-ын санхүүгийн нөхцөлийн индекс 2020 оны сүүл үеэс суларч эхэлсэн бөгөөд 2021 оноос илүү огцом буураад байна. Энэхүү бууралтад түс улсын засгийн газраас эдийн засгийг сэргээх бодлогын дэмжлэг үзүүлж байгаа нь голчлон нөлөөлж байна.

Зураг 1.12. Дэлхийн санхүүгийн нөхцлийн индекс



Эх сурвалж: ОУВС

Геополитикийн асуудал нь санхүүгийн зах зээлд тогтворгүй байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж, хөрөнгийн зах дээрх хувьцааны үнүүд буурав. Томоохон технологийн компаниудын үнэлгээ өссөнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцааны үнийг илэрхийлэгч Nasdaq, S&P 500, MSCI World индексүүд 2021 оны эцэст түүхэн дээд түвшиндээ хүрэв. Мөн олон улсын засгийн газруудаас Ковид-19 цар тахлын дараа эдийн засгийг сэргээх бодлогууд хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулагчдыг хувьцааны захад оролцох идэвхжилийг нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч Орос-Украины дайны нөхцөл байдал бий болсноор Европын бүсээс эхлээд дэлхий даяарх хөрөнгийн захууд дээрх хувьцааны үнийг 2021 оны эцсээс 2022 оны эхний хагас хүртэл унагах нөлөөг үзүүлж байна.

Хувьцаат компаниудын цаашдын орлогын төлөвийг Орос-Украины дайны нөхцөл байдал улам бүрхэг болгов. Ялангуяа, санхүүгийн эрсдэлд орсон компаниудын дийлэнх нь ОХУ-д байгаа бөгөөд тэдгээр компаниуд бусад улсын

худалдааны хориг арга хэмжээнд өртөж, түүхий эдийн дутагдалд орсноор орлого нь буурахад нөлөөллөө. Үүнтэй зэрэгцэн ОХУ-ын нийт гадаад өрийн 60% гаруй хувийг санхүүгийн бус бизнесийн компаниуд нь эзэлдэг учраас цаашид зээлийн эргэн төлөлтөө гүйцэтгэж чадахгүй болох эрсдэл нэмэгдэж байна.

Улмаар ОХУ дахь хориг арга хэмжээ, эдийн засгийн удаашрал, санхүүгийн эрсдэлтэй байдал нь тус улстай худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаатай европын бусад улсуудын эрчим хүчний компаниуд, томоохон төслүүдэд нөлөөлж байгаа нь ажиглагдлаа.

ОХУ дахь томоохон олон улсын компаниуд тус улсаас гарч байгаа нь цаашид ч ОХУ, Украины ойролцоо бүс нутгийн компаниудын орлого огцом буурах хүлээлтийг бий болгож байна.

Улмаар хөрөнгийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, эрсдэлийн түвшинг хэмжигч VIX² индекс нь цар тахлын дараа буюу 2021 онд буурч байсан ч дайны нөлөөгөөр 2022 оны 2-р улирлаас эргээд нэмэгдэх хандлага ажиглагдаж эхэллээ.


Мөнгөний хатуу бодлого нь засгийн газрын бондын өгөөжүүдийг өсгөхөд хүргэж байна.

Инфляц болон үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтөөс шалтгаалан АНУ-ын урт хугацаат бондын өгөөж 2021 оны сүүл хагасаас өссөн нь бусад хөгжингүй орнуудын бондын өгөөж өсөхөд түлхэц болов. Тухайлбал, 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн

² VIX индекс S&P 500-ын хувьцааны захын ирэх 30 хоногийн хэлбэлзлийг илэрхийлж, зах зээлийн эрсдэлийн түвшинг хэмжих индекс юм. Индексийн


байдлаар АНУ, Англи, Япон зэрэг улсуудын Засгийн газрын бондын өгөөж өмнөх оны мөн үеэс харгалзан 1.5 нэгж хувь, 1.5 нэгж хувь, 0.2 нэгж хувиар тус тус өсчээ.

Зураг 1.13. Хөрөнгийн захын гол индексүүд



Эх сурвалж: Блүүмберг

Зураг 1.14. Хөрөнгийн захын эрсдэлийн түвшинг хэмжих индекс



Эх сурвалж: Блүүмберг

АНУ-ын урт хугацаат бондын өгөөж ийнхүү үргэлжлэн нэмэгдэх нь бусад орнууд дахь бондуудын өгөөжид нөлөөлж, хүүний түвшинг өсгөх, улмаар эрсдэлийн нэмэгдлээр дамжин хөгжиж буй орнуудад

утга 12-оос доош бол хөрөнгийн захын үнийн хэлбэлзэл бага, 12-20 хооронд бол хэвийн, 20-оос дээш бол өндөрт тооцогддог байна.


дотоод хүүний түвшинг өсгөх нөлөөг үзүүлдэг билээ.

Хөгжиж буй орнуудын хувьд сүүлийн саруудад мөнгөний бодлогоо хатууруулж хүүг өсгөхийн зэрэгцээ дотоодын засгийн газрын бондуудын өгөөжийг мөн өсгөв. Улмаар дотоодын бондын зах дээрх гадаад хөрөнгө оруулагчдын оролцоо буурав.

Дэлхийн санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэн үед хөрөнгө оруулагчид илүү өндөр өртэй засгийн газруудыг санхүүжүүлэхийн тулд илүү их өгөөж шаардаж байна. Цар тахлаас шалтгаалан эдийн засгийн үйл ажиллагаа буурах үед дэлхийн улс орнуудаас компани, өрхүүдэд урьд өмнө нь байгаагүй илүү их хөрвөх чадвартай санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Ялангуяа, мөнгөний болон сангийн зөөлөн бодлогыг уялдуулж, бэлэн мөнгөний шилжүүлэг, дахин санхүүжилтийн тусламж, зээл, баталгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэв.

Хөгжиж буй орнуудын дотоодын бондын зах дээрх гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан засгийн газрын хэрэгцээт нэмэлт санхүүжилтийн өсөлтийн дийлэнхийг дотоодын банкууд хангав. Үр дүнд нь засгийн газар болон дотоодын банкуудын хоорондын санхүүгийн харилцаа холбоо эдгээр улсуудад нэлээд идэвхжив. Тухайлбал, цар тахлын өмнө хөгжиж буй орнуудын засгийн газрын нийт өр ба ДНБ-ний харьцаа дунджаар 52% байсан бол 2021 онд 67% хүртэл өссөн байна.


Зураг 1.15. Засгийн газрын урт хугацаат бондын өгөөжийн түвшин



Эх сурвалж: Блүүмберг

Тайлбар: 10 жилийн хугацаатай бондын өгөөж

Зураг 1.16. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: ОУВС

Засгийн газрын өрийн хэмжээ дийлэнх улсуудад өссөн ч хөгжиж буй орнуудын банкны салбарт ногдох эмзэг байдал илүү их өсөв. Тухайлбал, дотоодын банкны секторын нийт активт эзлэх засгийн газрын өрийн хувь 2021 онд хөгжиж буй орнуудад 17%, хөгжингүй орнуудад 7.5% байгаа нь хөгжиж буй орнууд дахь дахин санхүүжилтийн эрсдэл харьцангуй өндөр байгааг харуулж байна (ОУВС). Мөн хөгжиж буй орнуудын засгийн газрын өрийн дийлэнх нь гадаад валютаар байршиж байна.


Цаашид, улс орнуудын эдийн засгаа сэргээхэд шаардлагатай төсвийн чадамж, өрийн үйлчилгээний зардал нь харилцан адилгүй байгаа тул хөгжиж буй орны эдийн засгийн өсөлтийн төлөв нь хөгжингүй орноос сул байна (ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв, 2022). Улмаар, дунд хугацаандаа засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа хөгжиж буй улсуудад өсөх, хөгжингүй орнуудад буурах төсөөлөлтэй байна.

Иймд, хөгжиж буй орнуудын засгийн газрууд болон дотоодын банкуудын хооронд зээл, санхүүгийн нягт хамааралтай болоод байна. Энэ үед дэлхийн санхүүгийн нөхцөл чангарч буй шок нь санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.


Үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр орон сууцны үнийн өсөлт олон улсын хэмжээнд тогтвортой өсөлттэй байгаа нь мөчлөгийн эрсдэл тасралтгүй нэмэгдэж байгааг харуулж байна. Ковид-19 цар тахал эхэлснээс хойш хөгжингүй орнуудад орон сууцны үнэ маш ихээр өслөө. Мөн орон сууцны худалдаалах үнэ нь түрээсийн үнэтэй харьцуулахад илүү хурдтай өсч байгаа нь дэлхийн орон сууцны зах зээлийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, ипотекийн хүүгийн түвшинг өсгөхөд хүргэв. АНУ-д ипотекийн

хүүгийн түвшин 2022 онд огцом өссөн нь орон сууцны зах зээлийн худалдааны идэвхийг буурууллаа.

Зураг 1.17. Дотоодын банкны секторын активт эзлэх засгийн газрын өрийн хувь



Зураг 1.18. Олон улсын орон сууцны үнэ, түрээсийн үнийн индексийн өсөлт, 2019 оны 4-р улирлаас хойш



Эх сурвалж: OECD
Тайлбар: Үнийн индексийн өөрчлөлт 2022 оны 1-р улирлын байдлаар.

Шигтгээ 3. АНУ-ын Холбооны нөөцийн сангийн тэргүүний мэдэгдлийн дараа Ази, Номхон далайн улс орнуудын хувьцааны үнэ унаж эхлэв

Энэ оны 8 дугаар сарын 26-нд Жексон-Хоулд болсон эдийн засгийн симпозиум дээр Холбооны нөөцийн сан (ХНС)-гийн тэргүүн Жером Пауэлл АНУ-ын сүүлийн 40 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээд байгаа инфляцыг тогтоон барихын тулд хүүний өндөр түвшинг нэг хэсэгтээ л хадгална гэж мэдэгдсэний дараа Ази-Номхон далай (АНД)-н бүс нутгийн улс орнуудын хөрөнгийн биржийн индексүүд унаж эхэлсэн ажээ.

Пауэлл үнийн тогтвортой байдлыг хангах нь ХНС-аас хатуу арга хэмжээ авахыг шаардаж байгааг онцолсноор ХНС бодлогоо алгуур чангалах болов уу гэсэн хөрөнгө оруулагчдын найдлагыг үгүй хийв. Пауэлл “Эдийн засгийн үйл ажиллагааг ноцтойгоор хязгаарлах төлөв байдал руу бид бодлогоо ухамсартайгаар чиглүүлж байна” хэмээн мэдэгдсэн билээ.

“Хүүний өсөлт, эдийн засгийн өсөлтийн сааралт, хөдөлмөрийн захын сулралт нь инфляцыг тогтоон барина, гэхдээ өрхийн аж ахуйнууд болон бизнест өвдөлт өгнө. Энэ бол инфляцыг бууруулахад төлөх төлөөс юм. Гэвч үнийн тогтвортой байдлыг сэргээж чадахгүй бол үүнээс ч илүү өвдөлтийг мэдрэх болно” хэмээн Пауэлл онцлов.

Дээрх мэдэгдлийн дараа Нью-Йорк дахь хувьцааны үндсэн индексүүд 3 гаруй хувиар унасан байна. Улмаар 8 дугаар сарын 29-ний даваа гаригт Японы Nikkei 225 индексийн хаалтын ханш 2.7%-ийн уналт үзүүлсэн аж. Индексийн задаргааг авч үзвэл эрүүл мэндийн онлайн үйлчилгээ үзүүлдэг M3 Inc. (-5,7%) компани, технологийн Omron Corp. (-5.1%) компани болон кондиционер үйлдвэрлэдэг Daikin Industries Ltd. (-4.7%) компаний хувьцааны ханш хамгийн ихээр унажээ.

Хятадын Shanghai Composite 0.2%-иар, Хонконгийн Hang Seng 0.8%-иар тус тус унажээ. Хятадын эдийн засгийн өсөлт саарч эхэлсэн нь хөрөнгө оруулагчдын санааг түгшээж байна. Хятадын эрх баригчдаас Ковид-19-ийн “тэг бодлого” хэмээх хатуу хяналт хэрэгжүүлж байгаа нь эдийн засгийн төлөв байдлыг муутган, төв банкныг нь хүүгээ буулгахад түлхэж байгаа аж. Мэргэжилтнүүд эрэлт дэндүү сул байгаа тул Хятадын төв банкнаас хүүгээ бууруулахаас өөр аргагүй гэж үзэж байгаа аж. Сычуань мужид нүүрлэсэн эрчим хүчний хомсдол Хятадын автомашин болон ухаалаг гар үйлдвэрлэгчдэд том цохилт болсон билээ. Хятадын үндэсний статистикийн хорооны мэдээнээс харахад Хятадын томоохон аж үйлдвэрийн компаниудын эхний 7 сарын ашиг өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан аж. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээрхи хямрал Хятадын эрх баригчдын хувьд томоохон сорилт болох нь тодорхой байна.

Хонконгийн хувьд хөнгөн цагаан үйлдвэрлэгч China Hongqiao Group Ltd. (-5,5%), девелопер Longfor Group Holdings Ltd (-5,2%) болон электрон бараа үйлдвэрлэгч Techtronic Industries Co. Ltd. (-4,6%) компаний хувьцааны ханш хамгийн ихээр унажээ. Австралийн S&P/ASX 200 индекс болон Өмнөд Солонгосын Kospi индекс 2 орчим хувиар унасан байна. Дэлхийн чип болон хэрэглээний электроникийн томоохон үйлдвэрлэгч болох Samsung Electronics Co. компаний хувьцаа 2.2 хувиар унасан бол Hyundai Motor Co. Автомашин үйлдвэрлэгчийн хувьцаа 2.8 хувиар тус тус унажээ.

Эх сурвалж: Bloomberg, Америкийн Холбооны нөөцийн сан

2. Дотоод эдийн засгийн орчин

2.1 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал тэнцлийн алдагдал эрчимтэй тэлсэн нь төлбөрийн тэнцлийн дарамтыг эрс нэмэгдүүллээ. Монгол Улсын экспортын голлох эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ өссөн боловч БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтууд хэсэгчлэн болон бүрэн хаагдсанаар экспорт удааширч, барааны импортын зардал хурдтай нэмэгдсэн нь урсгал тэнцлийн алдагдлын тэлэлтэд хүргэж, төлбөрийн тэнцэл 2021 онд 221.6 сая ам.доллар, 2022 оны эхний хагаст 1058.0 сая ам.долларын алдагдалтай гарав (Зураг 2.1).

Түүнчлэн хөрөнгө санхүүгийн данс нь 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар нэмэгдсэн ч урсгал тэнцлийн том алдагдлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байлаа.

Эрдэс бүтээгдэхүүний хилийн үнэ эрчимтэй өссөн боловч БНХАУ-ын “Тэг Ковид” бодлого, хилийн боомтууд дээрх сааталтай холбоотойгоор экспортын биет хэмжээний өсөлт удаашралтай байв. Барааны экспорт, импорт цар тахлын эхэн үетэй харьцуулахад сэргэж, гэрээний үнээр тооцсон худалдааны тэнцэл 2021 онд 1,370 сая ам.долларын ашигтай гарсан боловч 2022 оны эхний хагаст 425.5 сая ам.долларын алдагдалтай гарав. Үүнд уул уурхайн экспортын биет хэмжээний өсөлт удаашралтай байсан нь голлон нөлөөллөө (Зураг 2.2).

Улмаар үйлчилгээний импорт огцом тэлж, анхдагч орлого буюу гадаад бонд, зээл, үнэт цаас, ногдол ашгийн төлбөрийн шилжүүлэг


нэмэгдэж байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж байна.

Зураг 2.1. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Зураг 2.2. Гадаад худалдааны тэнцэл (гэрээний үнээр, сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

2021 оноос эхлэн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, гадаад инфляц, тээврийн зардлын өсөлтөөс шалтгаалан импортын төлбөр хурдтай тэлж байна. 2021 онд цар тахлын хязгаарлалтууд суларч хэрэглээний бараа болон хөрөнгө оруулалтын импорт голлон өссөн бол 2022 оны эхний хагаст


хэрэглээний импорт эрчимтэй өссөн байна. Тодруулбал, хилээр хугацаандаа нэвтэрч чадаагүй бараануудын тээвэрлэлт, хадгалалтын зардал өсөхийн зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлт нь манай улсын шатахууны үнийг нэмэгдүүлж, тээврийн зардал, импортын барааны үнийг ихээхэн өсгөж байна.

Хөрөнгийн урсгал сайжирч байна. Ялангуяа гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал нэмэгдсэнээс шалтгаалан хөрөнгө, санхүүгийн данс 2021 онд өмнөх оноос 30.4 хувь, 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар нэмэгдэв (Зураг 2.3). Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтөд уул уурхай, олборлолтын салбар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Мөн, 2020 оны дунд үеэс эхлэн дэлхий даяар санхүүгийн нөхцөл суларсан таатай боломжийг ашиглан 2020-2021 онд өрийн дахин санхүүжилтийг амжилттай хийсэн болон донор санхүүжилтүүдийн нөлөөгөөр гадаад зээлүүд нэмэгдсэн нь хөрөнгө, санхүүгийн дансны тэнцэлд дэмжлэг үзүүлэв.

Төлбөрийн тэнцэл эрчимтэй муудсан нь Төв банкны гадаад валютын интервенц хийх шаардлагыг нэмэгдүүлж, гадаад валютын албан нөөц ихээхэн буурав. Эдийн засгийн идэвхжилээс шалтгаалсан импортын тэлэлт, хилийн боомтуудын саатлаас үүдсэн экспортын удаашрал нь төлбөрийн тэнцлийг эрчимтэй муутгаж байсан тул Төв банкнаас төгрөгийн ханшийн огцом хэлбэлзлээс сэргийлэх зорилгоор гадаад валютын интервенцийг 2021 оны сүүлийн хагасаас эхлэн нэмэгдүүлэв. Улмаар гадаад валютын албан нөөц 2022 оны 6 дугаар сарын эцсийн


байдлаар өмнөх оны мөн үеэс 34.5 хувиар буурч, 3097.0 сая ам.доллар болов. Энэ нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 4.1 сарын хэрэгцээг хангах түвшин бөгөөд олон улсын жишиг доод түвшин болох 3 сартай харьцуулахад хангалттай хэмжээнд байна (Зураг 2.4).

Зураг 2.3. Санхүүгийн данс /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.4. Гадаад валютын нөөц /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн саруудад цар тахал, геополитикийн асуудлаас шалтгаалан тодорхойгүй байдал нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширч байгаа нь цаашид түүхий эдийн үнэ, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2.2 ӨРХ, ИРГЭД


Иргэдийн хэрэглээний болон ипотекийн зээлийн өсөлтөөс шалтгаалан өрхийн өрийн түвшин алгуур нэмэгдэж байна. Цар тахлын дараах эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд банкуудын зээл олголт тэлж, өрхийн өрийн түвшин хэрэглээний болон ипотекийн зээлийн хүрээнд нэмэгдэв. Тухайлбал макро зохистой бодлогын болон цар тахлын нөлөөгөөр банкны хэрэглээний зээл олголт 2019-2020 онд эрчимтэй буурч байсан бол 2021 оны 2 дугаар хагасаас хэрэглээний зээл сэргэж, 2022 оны 6 дугаар сарын эцэст өмнөх оны мөн үеэс 23.2 хувиар өссөн байна (Зураг 2.5, 2.6).

Харин ипотекийн зээлийн хувьд 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эцэс гэхэд 1 их наяд төгрөгийг зарцуулсан нь зээл олголт эрчимжиж, өрхийн өрийн түвшин 2021-2022 онд алгуур нэмэгдэхэд нөлөөллөө. Ипотекийн зээл 2018 оноос 2020 он хүртэлх хугацаанд 3-6 хувийн тогтмол өсөлттэй байсан бол 2021 оны эцэст 14.9 хувь, 2022 оны 2 дугаар улиралд 15.5 хувьд хүрч өсөв (Зураг 2.6). Ипотекийн зээлийн хүү буурч, зээлийн санхүүжилт нэмэгдсэнээр өрхүүд ийнхүү орон сууцны зээлд хамрагдах сонирхол нэмэгдсэн байна. Гэвч цар тахлын үеийн бодлогын арга хэмжээний хүрээнд ипотекийн зээлийн төлбөрийг 2022 оныг дуустал хойшлуулсан тул энэхүү хугацаа дуусгавар болмогц өрхийн өрийн дарамтаас үүдэх эрсдэл нэмэгдэхээр байна.

Түүнчлэн, 2020 оны эцсийн байдлаар дөнгөж 2.3 хувиар өсөж байсан иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл 10 их


наядын хөтөлбөрийн нөлөөгөөр 2021 оны эцэст өмнөх оны мөн үеэс 35.7% хувиар өсөж, эрс нэмэгдэв. Харин 2022 оны эхний 2 улиралд тус зээлийн өсөлт удаашрав (Зураг 2.6).

Зураг 2.5. Өрхийн өр, ДНБ-ий харьцаа



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Зураг 2.6. Банкуудын иргэдийн зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн өр орлогын харьцаа тогтмол байна. 2022 оны эхний улиралд цалингийн болон хэрэглээний бусад зээлийн үлдэгдлийн хувьд өрхийн өр орлогын харьцаа өмнөх үеүдтэй харьцуулахад хэлбэлзэл өндөр байсан бол 2


дугаар улиралд тогтмол түвшинд хадгалагдаж байна (Зураг 2.7).

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад мөн иргэдийн зээл эрчимтэй нэмэгдэх хандлага ажиглагдав. Тодруулбал, ББСБ-ын иргэдийн зээл энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 62.6 хувиар өсөж, зээлийн үлдэгдэл 2.37 их наяд төгрөгт хүрчээ (Зураг 2.8).

Цалин хөлсний орлогын нөлөөгөөр өрхийн дундаж орлого нэмэгдлээ. ҮСХ-ны мэдээллээр 2022 оны 2 дугаар улиралд өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өсөв. Өрхийн орлого ийнхүү өсөхөд цалин хөлсний орлого энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээнээс олох орлого 22.7 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөллөө (Зураг 2.9).


Өрхийн зарлага 2021 оны 4 дүгээр улирлаас эхлэн эрчимтэй өсөв. 2020 онд хөл хорио, хязгаарлалтын дэглэмтэй холбоотойгоор өрхийн зарлага буурч байсан бол эдийн засгийн үйл ажиллагаа сэргэхтэй зэрэгцэн 2021 оны эхний 3 улиралд өрхийн зарлага алгуур нэмэгдэв. Харин эдийн засгийн идэвхжил, импортын өртөг зардал, хүнс, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан өрхийн дундаж зарлага 2022 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар огцом өслөө. Өрхийн зарлага ийнхүү өсөхөд хүнсний зардал 15.3 хувиар, хүнсний бус зардал 22.8 хувиар, бусад зарлага 38.2 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлөв (Зураг 2.9).

Зураг 2.7. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өр орлогын харьцаа




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.8. Банк болон ББСБ-ын иргэдийн зээл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Зураг 2.9. Өрхийн орлого, зарлагын зөрүү /мян төгрөг/



Эх сурвалж: ҮСХ

Иргэдийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь банкуудын хувьд буурч буй боловч банкны бус санхүүгийн салбарт нэмэгдэж эхлэх хандлагатай байна.


Монголбанкнаас 2019 оноос эхлэн банкны хэрэглээний зээлд мөрдүүлж буй зохицуулалттай холбоотойгоор ББСБ-ын иргэдийн зээл эрчимтэй өсч, зээлийн чанарт сөргөөр нөлөөлж байж болзошгүй байна. Харин банкуудын иргэдийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 оны 3 дугаар улирлаас хойш тасралтгүй буурсаар байна. Үүнд цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор ипотека, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зориулалтаар иргэнд олгосон зээлийн хугацааг сунгах, зээлийн ангилал бууруулах хугацааг уртасгах, ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх зэрэг хөнгөлөлтийн арга хэмжээнүүд нь зээлийн эргэн төлөлт, чанарт эергээр нөлөөлсөн байх боломжтой (Зураг 2.10).

Цар тахлын үеийн хөнгөлөлт, зохицуулалтын арга хэмжээнүүд дуусгавар болж байгаа учир иргэдийн зээлийн чанар цаашид муудаж болзошгүй байна.

Тухайлбал банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооны чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 онд буурсан боловч 2022 оны 2 дугаар улирлаас өсөх хандлагатай байна. Энэ нь цар тахлын үеийн зээлдэгчдэд чиглэсэн хөнгөлөлтийн арга хэмжээ, зохицуулалтууд дуусгавар болсноор иргэдийн хэрэглээний болон ипотекийн зээлийн төлбөрийн дарамт нэмэгдэж, зээлийн эргэн төлөлтөнд хүндрэл учрах, зээлийн чанар муудах


эрсдэлтэй байгааг харуулж байна (Зураг 2.11, 12).

Зураг 2.10. Банкуудын иргэдийн чанаргүй зээл, нийт зээлд эзлэх хувь /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.11. ББСБ-ын чанаргүй зээл, эзлэх хувь /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Зураг 2.12. ХЗХ-ны зээл, зээлийн чанар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Ипотекийн зээл ба орон сууцны үнэ

Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн нөлөөгөөр иргэдийн орон сууцны зээл эрчимтэй нэмэгдэв. Тухайлбал, орон сууцны зээлийн жилийн өсөлтийн хувь 2021 онд 6.3 хувиас 14.9 хувьд хүрч огцом нэмэгдсэн бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 нэгж хувиар өссөн байна (Зураг 2.13).


Тухайн улирлын шинээр олгосон ипотекийн зээлийн статистикаас харахад 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн Монголбанкны эх үүсвэрийн санхүүжилтээс³ гадна арилжааны банкны өөрийн эх үүсвэрийн зээл 2021 оны 2 дугаар улирлаас хойш эрчимтэй нэмэгдсэн байна. Харин 2022 он гарснаар зээл олголт буурч энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 14 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байв (Зураг 2.14).

Нийт төлөгдсөн зээл болон хугацаанаас өмнө төлөгдсөн зээлийн дүн 2020 оны 2 дугаар улирлаас эхлэн эрчимтэй өссөн бол 2021 оны 3 дугаар улирлаас эхлэн саарлаа. (Зураг 2.15).

Активын ангиллын зохицуулалт, зээлийн эргэн төлөлт хойшлуулсантай холбоотойгоор ипотекийн зээлийн чанар сайжирсан ба тус зохицуулалт дуусгавар болсноор зээлийн чанар муудаж болзошгүй юм. Хугацаа хэтэрсэн зээл болон чанаргүй


зээлийн ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 2021 оны 1 дүгээр улирлаас хойш эрчимтэй буурч 2022 оны 6 сарын эцсийн байдлаар 0.7 хувь, 1.6 хувьд тус тус хүрээд байна (Зураг 2.16).

Зураг 2.13. Ипотекийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.14. Тухайн улиралд шинээр олгосон болон төлөгдсөн ипотекийн зээл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

³ Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТТБ)


Чанаргүй зээлийн хувь буурахад ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан 2022 оныг дуустал хойшлуулсан нь нөлөөлөв. Гэвч 2023 оны эхнээс ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулсан зохицуулалт дуусгавар болж иргэдэд өрийн дарамт нэмэгдэх, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байна.

Орон сууцны үнэ өсөхөд нийлүүлэлт талаасаа барилгын өртгийн өсөлт, эрэлт талаасаа 10 их наядын хөтөлбөрөөс шалтгаалсан орон сууцны зээлийн тэлэлт голлон нөлөөлөв. 2021 оны 1 дүгээр улирлаас эхлэн барилгын өртгийн индексийн өсөлтийг дагаад орон сууцны үнийн индекс /ОСҮИ/ эрчимтэй өсчээ. Энэ нь нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийг харуулж байна. Гэвч шинэ орон сууцны үнийн индексийн өсөлтийг даган хуучин орон сууцны үнийн индекс хурдтай өссөн нь 10 их наядын хөтөлбөрөөс шалтгаалсан орон сууцны зээлийн тэлэлт буюу эрэлтийн хүчин зүйлийн нөлөө, мөн үнийн хөөсрөл үүсч байж болзошгүйг илтгэж байна (Зураг 2.17).

Орон сууцны зах зээлийн хувьд эрэлт, нийлүүлэлт талаас ипотекийн зээлийн санхүүжилт, барилгын өртгийн өсөлт нь голлох хүчин зүйлс болж байгаа учир цаашид ипотекийн зээлийн санхүүжилт буурах, барилгын өртгийн өсөлт саарах нь орон сууцны үнийн уналтыг бий болгох эрсдэлтэй байна. Түүнчлэн зээлийн эргэн төлөлт хойшлуулах зохицуулалт дуусгавар болсноор өрхийн өрийн дарамт ихээхэн нэмэгдэж, зээлийн эргэн төлөлт муудах,

банкны салбарт эрсдэл үүсгэж болзошгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Зураг 2.15. Хугацаанаас өмнө төлөгдсөн зээл, эх үүсвэрээр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.16. Ипотекийн зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк

Хөдөлмөрийн захын төлөв сайжирсаар байгаа хэдий ч цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2018-2019 онд харьцангуй тогтвортой буюу 60 орчим хувьтай байсан бол цар тахлын нөлөөгөөр эрчимтэй буурч 2021 оны 1 дүгээр улиралд 54.9 хувьд хүрсэн ба 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар

58.0 хувь болж эргэн сэргээд байна (Зураг 2.18).

Түүнчлэн 2021 оны эхний 3 улиралд хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурч байсан ч 4 дүгээр улирал болон энэ оны эхний улиралд хөдөлмөр эрхлэлт буурч, ажилгүйдлийн түвшин эргэн нэмэгдэв. Тухайлбал хөдөө аж ахуй, усан хангамж, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, санхүү, захиргааны салбарт ажиллагчдын тоо буурав.


Улсын дундаж цалин энэ оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар нэмэгдсэн боловч инфляцийн нөлөөгөөр бодит дүнгээр 4.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өрхийн секторыг харахад цалин, хөлсний орлого нэмэгдсэн ч өрийн түвшин нэмэгдсэн, хөдөлмөр эрхлэлт буурч, ажилгүйдэл нэмэгдсэн зэргээр ерөнхий төлөв таатай бус байна.

Түүнчлэн, хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт өрхийн бодит орлогод томоохон дарамтыг учруулж байгаа бөгөөд цар тахалтай холбоотой төсвийн дэмжлэг, арга хэмжээнүүд дуусгавар болж байгаа нь өрхийн санхүүгийн тогтвортой байдалд томоохон эрсдэлийг дагуулж


байна. Улмаар өрхийн бодит орлого сэргэхгүй нөхцөлд өрхүүд хэрэглээгээ багасгаж, энэ нь цаашлаад эдийн засгийн сэргэлтийг удаашруулж, төлөвийг муутгах эрсдэлтэй.

Зураг 2.17. Орон сууцны үнийн болон өртгийн индекс



Эх сурвалж: YCX ба Тэнхлэг зууч

Зураг 2.18. Ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: YCX

2.3 АЖ АХУЙН НЭГЖ

Эдийн засгаа сэргээх хөтөлбөрийн нөлөөгөөр үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоох аж ахуйн нэгжүүдийн тоо буурч байна. Тодруулбал, 2022 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар өнгөрсөн жилийн мөн үеэс хойш 130 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон бол цар тахлын үед буюу 2021 оны 1 дүгээр улирлын эцэст 2136 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоож байжээ. Гэвч, худалдаа, үйлчилгээний салбаруудад үйл ажиллагааны доголдол хамгийн их буюу бусад салбаруудтай харьцуулахад хамгийн их тооны аж ахуйн нэгжүүд түр болон бүрэн байдлаар үйл ажиллагаагаа зогсоосон байна (Зураг 2.19, 2.20).


Мөн шинээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэж байна. Тодруулбал үйлчилгээний салбарт шинээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн тоо 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, мэдээлэл холбооны салбарт 8.1 хувиар нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болов.

Хэдий шинээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо эдийн засгийн бүх салбарт нэмэгдэх хандлагатай байгаа боловч үйл ажиллагаагаа зогсоож буй аж ахуйн нэгжийн тоо илүү давамгайлж байна.

Эдийн засгийн сэргэлт салбаруудад харилцан адилгүй байна. Салбаруудын борлуулалтаас харахад энэ оны эхний хагас жилийн байдлаар боловсруулах, эрчим хүч, худалдааны болон агаарын тээврийн салбаруудын өсөлт нэмэгдэж, сэргэх

хандлага ажиглагдаж байгаа бол уул уурхай, төмөр замын салбарын үйлдвэрлэл агшлаа.

Зураг 2.19. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /мянга/



Эх сурвалж: ҮСХ

Зураг 2.20. Үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо /мянга/



Эх сурвалж: ҮСХ

Хүснэгт 2.1. Эдийн засгийн зарим салбаруудын борлуулалтын орлого

Салбар	2020.6	2021.6	2022.6	2022.6/2021.6
	тэрбум төгрөг			өөрчлөлт
Аж үйлдвэр	7499	12275	10637	-13.3%
Уул уурхай, олборлолт	4952	8896	7116	-20.0%
Боловсруулах	1842	2589	2678	3.4%
Цахилгаан, хий	639	709	749	5.6%
Ус хангамж	66	81	94	16.4%
Худалдаа	10180	12453	16816	35.0%
Төмөр замын тээвэр	366	393	325	-17.2%
Агаарын тээвэр	87	72	146	101.5%

Эх сурвалж: ҮСХ

Дотоодын худалдааны салбарын борлуулалт энэ оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өссөн ба энэ нь 2021 оны түрш агшаад байсан өрхийн хэрэглээ энэ оны 1 дүгээр улирлаас эхлэн сэргэж, дотоод эрэлт нэмэгдсэнтэй холбоотой юм.

Харин ДНБ-ий томоохон хувийг эзэлдэг уул уурхай олборлолтын борлуулалтын орлого энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар буурсан ч, хилийн хязгаарлалт суларсантай холбоотойгоор 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.3 хувийн өсөлт үзүүлэв. Иймд цаашид уул уурхайн салбар аажимдаа сэргэх хандлагатай байна.

Боловсруулах салбарын борлуулалт энэ оны эхний 6 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар өссөн бөгөөд үүнд хувцас үйлдвэрлэл, тавилга, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.1).

Эхний хагас жилийн байдлаар банкуудын шинээр олгосон бизнесийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар нэмэгджээ.

Тэр дундаа хөдөө аж ахуй, худалдаа болон барилгын салбарт зээл олголт нэмэгдсэн дүнтэй байна. Банкны системийн нийт зээлийн үлдэгдэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өссөн бөгөөд зээлийн өсөлтийн 30.6 хувийг худалдааны салбар, 19.9 хувийг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл бүрдүүлжээ (Зураг 2.21, 2.22).

Зураг 2.21. Банкуудын шинэ зээл олголт /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.22. Зээлийн үлдэгдлийн өсөлт, салбаруудаар, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.23. Төгрөгийн олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн жигнэсэн дундаж хүү бага зэрэг өсөх хандлагатай байна. Энэ нь Монголбанкнаас инфляцийн эсрэг удаа дараа авч хэрэгжүүлж буй бодлогын хүүгийн өсөлт болон гадаад эдийн засгийн тодорхой бус байдал, эрсдэл нэмэгдэж байгаагаас үүдэн банкууд зээлийн хүүг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээ, хугацааг бууруулах замаар зээлийн нөхцөлийг бага зэрэг чангаруулсантай холбоотой юм. Тухайлбал, барилга, худалдаа, боловсруулах салбарт олгосон зээлийн дундаж хүү өмнөх оны мөн үеэс хойш нэмэгджээ. Харин 10 их наядын хөтөлбөрийн хөдөө аж ахуйг дэмжих зээлийн санхүүжилтийн нөлөөгөөр тус салбарт олгосон зээлийн дундаж хүү 2021-2022 онд өндөр хэлбэлзэлтэй байв (Зураг 2.23).


Зээлийн төвлөрөл нэмэгдэх хандлагатай байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийн 77.6 хувийг голлох дөрвөн салбар буюу худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн үзүүлэлт болов. Энэ нь банкны санхүүгийн зуучлал, ашигт ажиллагаа эдгээр салбаруудаас илүү өндөр хамааралтай болж байгааг харуулж байна. Түүнчлэн, нийт зээлийн үлдэгдлийн бараг тал хувь нь 5 тэрбумаас дээш төгрөгийн үлдэгдэл бүхий маш цөөн тооны дансанд төвлөрч байгаа нь банкны салбарын зээлийн эрсдэл өндөр байгааг харуулж байна (Зураг 2.24-2.26).

Зураг 2.24. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн төвлөрөл




Эх сурвалж: Монголбанк
Тайлбар: Төвлөрлийн харьцааг хамгийн их хувь эзлэх 4 салбарын нийлбэр дүнгээр тооцов.

Зураг 2.25. Хувийн байгууллагын зээлийн төвлөрөл, зээлийн дүн ба дансны тоогоор



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.26. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл болон чанар, салбараар



Эх сурвалж: Монголбанк


Хувийн байгууллагын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь харьцангуй тогтвортой байгаа хэдий ч үлдэгдлийн хэмжээ нь эрчимтэй өсч байна. Тухайлбал, хувийн байгууллагад олгосон чанаргүй зээлийн үлдэгдэл 2022 оны 6 дугаар сард жилийн 17.0 хувиар буюу 238.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Харин зээл олголт өсч, нийт зээлийн үлдэгдэл нэмэгдэж буйн нөлөөгөөр чанаргүй зээлийн эзлэх хувь харьцангуй тогтвортой байна (Зураг 2.27).

Уул уурхай, боловсруулах, барилгын салбарт чанаргүй зээлийн хувь хамгийн өндөр буюу эрсдэл ихтэй байгаа бол худалдааны салбарын зээлийн чанар сайжирч байна. Тухайлбал, уул уурхайн салбарт зээлийн чанаргүйтэл хамгийн өндөр буюу нийт зээлийн 36.9 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байгаа нь томоохон эрсдэл дагуулж байна. 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар уул уурхайн салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл 556.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилийн мөн үеэс 46.1 хувиар өсөв. Тус салбарын чанаргүй зээлийн хувь нэмэгдэж байгаа нь банкны эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлж, цаашид уул уурхайн зээл олголт буурахад нөлөөлж байна (Зураг 2.27).

Аж ахуй нэгжүүдийн сэргэлт удаашралтай байгаа нь борлуулалтын орлого буурах, зээлийн чанар муудахад нөлөөлж байна. Уул уурхай, болон тээвэр агуулахын салбарын чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдсэн нь БНХАУ-ын Тэг-Ковид бодлогын улмаас хилийн хязгаарлалт чангарсан болон гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй байдлаас үүдэн аж ахуйн


нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоож байгаатай холбоотой юм. Тодруулбал, 2020 онд уул уурхайн салбарын 144 аж ахуйн нэгж, 2021 онд 305 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон байна.

Зураг 2.27. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн хувь, голлох салбарууд



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.28. Боловсруулах салбарын үйл ажиллагаагаа зогсоосон аж ахуйн нэгжийн өсөлт болон чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монголбанк

Цар тахлаас шалтгаалан боловсруулах салбарын үйл ажиллагаа доголдож, нийт хувийн байгууллагын чанаргүй зээлийн 22.8 хувийг бүрдүүлэх болов. 2021 онд уг салбарын 1843 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа түр болон бүрэн байдлаар зогсоосон ба одоогийн байдлаар үйл

ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо цар тахлын өмнөх түвшинд хүрч чадаагүй байгаа нь уг салбарт сэргэлт удаашралтай байгааг харуулж байна (Зураг 2.28).

Худалдааны салбарын чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ 2018 оны сүүлчээс тогтвортой буурч байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар худалдааны салбарын хувьд 86.7 тэрбум төгрөг буюу тухайн салбарын нийт зээлийн 2.6 хувь нь чанаргүй зээл байна. Нийт зээлийн үлдэгдлийн гуравны нэгийг эзэлдэг уг салбарын хувьд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хувийн байгууллагын нийт чанаргүй зээлийн 5.3 хувийг эзэлж байна. Энэ нь худалдааны салбарт зээлийн эрсдэл харьцангуй бага бөгөөд зээл олголтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байгаа нь сайшаалтай үзүүлэлт юм.

Хувийн салбарт эрсдэл хуримтлагдах нь банкууд зээлийн шалгуур болон нөхцлөө

чангаруулах, зээлийн хүүгээ өсгөх, хувийн байгууллагад олгох зээлийн хэмжээ буурахад нөлөөлж байна. Тухайлбал, 2022 оны 2 дугаар улирлын банкны зээлийн төлөвийн судалгаагаар банкууд ирэх гурван сард барилга, хөдөө аж ахуй, боловсруулах салбарт олгох зээлийн хэмжээгээ нэмэгдүүлэх бол уул уурхай, худалдаа үйлчилгээний салбарт олгох зээлийн хэмжээгээ бууруулах төлөвтэй байна гэжээ.

Цаашид хөрөнгө оруулалтын зориулалттай бодит секторын зээл олголт буурч, голлох салбаруудын чанаргүй зээлийн хэмжээ өсөх нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Түүнчлэн, өндөр инфляц, гадаад эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зардал өсөж, ашигт ажиллагаа, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2.4 УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсөв


Цар тахлын дараах сэргэлтээс шалтгаалан төсвийн тэнцэл сайжирч байгаа ч зардал өндөр хэвээр байна. 2022 оны 6 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7347.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 8191.9 тэрбум төгрөгт хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 844.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав (Зураг 2.29).

Төсвийн орлого уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспорт, үнийн хэлбэлзэлд ихээхэн мэдрэмтгий байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайн салбарын орлого бүрдүүлдэг ба 2021-2022 онд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ өндөр байсан нь төсвийн орлогод дэмжлэг үзүүлэв. Гэвч хилийн боомтын доголдлоос шалтгаалан 2022 оны эхний улиралд экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 62.2 хувиар буурсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, төсвийн орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөв.


Харин энэ оны 2 дугаар улиралд хилийн хязгаарлалт суларснаас шалтгаалан уул уурхайн экспортын биет хэмжээ эрчимтэй нэмэгдлээ. Үүний үр дүнд нүүрсний экспортын үнийн дүн 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2.4 тэрбум долларт хүрч өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс даруй 2.3 дахин нэмэгдсэн нь төсвийн орлогод эерэг нөлөө үзүүлж байна.

Иймд урт хугацаандаа төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд дэлхийн зах зээлийн эерэг, сөрөг шокуудад өртөмтгий буюу дан ганц уул уурхайн салбараас хэт их хамааралтай байдлыг бууруулах шаардлагатай юм.

Зураг 2.29. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний 6 сарын байдлаар, тэрбум төг)



Зураг 2.30. Нэгдсэн төсвийн зарлагын жилийн өөрчлөлт



Цар тахлын үеийн төсвийн зардлын өсөлтийн голлох хувийг нийгмийн халамж, тэтгэмж бүрдүүлж байсан бол 2022 оны эхнээс хөрөнгө оруулалтын зардлын нөлөө нэмэгдэж байна. Тухайлбал, 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийгмийн халамжийн зардал ихээхэн буурсан бол хөрөнгийн зардал болон бусад урсгал зардлын өсөлт төсвийн нийт зардлыг өсгөхөд голлон нөлөөлсөн байна (Зураг 2.30).


Улсын гадаад өр

Монгол улсын гадаад өрийн дарамт өндөр хэвээр байна. Монгол Улсын нийт гадаад өр 2022 оны эхний улирлын байдлаар 33.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсөв. Үүнээс Засгийн газрын гадаад өр 8.4 тэрбум доллар буюу 24.7 хувийг, Төв банкны гадаад өр 2.6 тэрбум доллар буюу 7.7 хувийг бүрдүүлж байна (Зураг 2.31).


2022 оны 12 дугаар сард Чингис бондын 137 сая доллар, 2023 онд Гэрэгэ бондын 536.6 сая доллар болон 2024 онд Хуралдай бондын 600 сая долларын өрийг төлөх хуваарьтай байна. Түүнчлэн, 2023 онд Монгол Улсын Хөгжлийн банк нь 30 тэрбум иен буюу 225 сая ам.долларын Самурай бонд болон 500 сая

ам.долларын Евро бондын төлбөрийг барагдуулна (Зураг 2.32).

Зураг 2.31. Монгол Улсын гадаад өрийн бүтэц, тэрбум ам.доллар



Зураг 2.32. Засгийн газар болон Хөгжлийн Банкны гадаад бондын төлбөрийн хуваарь, сая ам.доллар



Эх сурвалж: Сангийн яам, Хөгжлийн Банк

Шигтгээ 4. Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал


“Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал” нь санхүүгийн системийн эмзэг байдлын ерөнхий дүр зургийг харуулах, бодлого боловсруулагч болон зах зээлд оролцогчдод зах зээлд үүсэж болзошгүй эрсдэлийн талаарх чиг хандлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Монгол Улсын санхүүгийн салбарын эмзэг байдлыг илтгэгч үзүүлэлтүүдийг (i) макро эдийн засаг, (ii) гадаад сектор, (iii) мөнгөний зах, (iv) хөрвөх чадвар, санхүүжилт, (v) банкны салбарын ашигт ажиллагаа, (vi) хөрөнгийн зах гэсэн эрсдэл үүсэх боломжит ангиллаар бүлэглэн, эрсдэлийн зэргийг жил, улирал, сарын давтамжтайгаар тодорхойлж байна.

Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексээс харахад 2021 оны сүүлийн хагасаас эрсдэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд үүний ихэнх хувийг макро эдийн засаг, банкны сектор, хөрөнгийн захын эрсдэл бүрдүүлж байв. Харин 2022 оны эхнээс нийт эрсдэл буурах чиглэлд өөрчлөгдлөө. Үүнд банкны сектор, хөрвөх чадвар, хөрөнгийн захын эрсдэл буурч байгаа нь голлон нөлөөлөв.


2022 оны 2 дугаар улирлын байдлаар системийн эрсдэл өмнөх улирлаас буурсан төлөвтэй байна. Банкны сектор, мөнгөний зах, хөрвөх чадвар, санхүүжилтэд гарсан эерэг өөрчлөлтүүд эрсдэл буурах нөлөөг үзүүлэв. Банкны ашигт ажиллагаа сайжирч, активын өгөөж нэмэгдсэн, түүнчлэн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайжирснаар банкны секторын эрсдэл 2022 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас буурсан. Топ-20 индекс болон орон сууцны үнийн өсөлтийн урт хугацааны трендүүдээсээ зөрөх зөрүү бага зэрэг буурснаар хөрөнгийн захын эрсдэл тайлант улиралд өмнөх улирлаас буурах чиглэлд өөрчлөгдлөө.

Банкны сектор, хөрвөх чадвар, хөрөнгийн захад эрсдэл буурсан хэдий ч макро эдийн засгийн эрсдэл өндөр хэвээр байна. Өмнөх улиралтай харьцуулахад инфляцын түвшин өссөн, гадаад валютын албан нөөц ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа буурсан, бодит мөнгөний нийлүүлэлтийн урт хугацааны трендээсээ зөрөх зөрүү нэмэгдсэн зэрэг нь макро эдийн засгийн эрсдэл нэмэгдэхэд нөлөөлөв. Засгийн газрын бондын өгөөж нэмэгдсэн болон урсгал дансны алдагдал өндөр хэвээр байгаа нь гадаад секторын эрсдэлд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Зураг 2.33 Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн зураглал



Эх сурвалж: Монголбанк, Судлаачийн тооцоолол



Энэхүү өөрчлөлтийг зээлдэгчийн төрлөөр салгаж үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдааны болон хэрэглээ, өрхийн аж ахуйн зээл хамгийн өндөр буюу 33.8 хувь болон 33.6 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн өсөлтийн хамгийн их хэсэг буюу 29.0 хувийг иргэдэд олгосон зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бол том аж ахуйн нэгжид олгосон зээлийн өсөлт 17.5 хувийг, дунд аж ахуйн нэгжид олгосон зээлийн өсөлт 14.3 хувийг, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгосон зээлийн өсөлт 10.9 хувийг тус тус бүрдүүлж байна.


Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн сектороор авч үзэхэд өмнөх онтой харьцуулахад эдийн засгийн голлох бүх салбаруудын зээл өссөн байна. Үүнээс худалдааны болон үл хөдлөх салбаруудын зээл хамгийн өндөр буюу харгалзан 33.8 болон 33.6 хувийн өсөлт үзүүлсэн нь Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн үр дүн байна. Дараагийн өндөр өсөлт үзүүлсэн салбар болох хэрэглээ өрхийн аж ахуйн салбарын зээлийн жилийн өсөлт 26.6 хувь

байгаа нь Ковид-19 цар тахлын үеийн хөл хорио суларч иргэдийн хэрэглээний зардал нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэхээр байна (Зураг 3.3).

Цар тахлын үед Засгийн газар, Монголбанкны зүгээс бодит секторыг шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээр хангах, зээл олголтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлогын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүд 2022 оны эхний хагас жилийн байдлаар үргэлжлэн хэрэгжиж байна.

2022 оны 2 дугаар улирлын байдлаар банкны системийн хэмжээнд олгох боломжит зээлийн дүн 3.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь олгох боломжит зээлийн дүн 5.0 их наяд төгрөг байсан 2021 оны эцэстэй харьцуулахад 1.3 хувиар буурсан нь бодит эдийн засгийн өнөөгийн байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр банкны зээлийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбоотой байж болзошгүй.

Зураг 3.3. Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар (2022.06.30), тэрбум төгрөг



Хэдийгээр манай улс дахь цар тахлын тархалт буурсан, хорио цээрийн дэглэмийг

сулруулсантай холбогдуулан бодит эдийн засаг, банкны салбар сэргэх хүлээлттэй

байсан ч олон улсад өрнөж буй нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, төлөвөөс шалтгаалан банкууд эрсдэлийн аппетит болон зээл олголтыг нэмэгдүүлэхгүй байж болзошгүй байна.

Банкны системийн чанаргүй зээл


2022 эхний хагас жилд банкны системийн чанаргүй зээл 1.9 их наяд төгрөг, анхаарал хандуулах зээл 1.4 их наяд төгрөгт хүрч, нийт эргэн төлөлтийн доголдолтой зээлийн дүн 3.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээл нийт зээлийн 8.2 хувь, эргэн төлөлтийн доголдолтой зээл 14.3 хувийг тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 нэгж хувиар буурсан бөгөөд энэ нь зээлийн чанар сайжирснаас бус харин системийн нийт зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна (Зураг 3.4, 3.5).

Эрсдэлийн сангийн хүрэлцээ

Банкны системийн нийт зээлийн үлдэгдэл 2022 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар өсөж 23.8 их наяд төгрөгт хүрсэн бол зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар буюу 182.5 тэрбум төгрөгөөр өсжээ (Зураг 3.6).


Эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа буюу эрсдэлийн сангаар чанаргүй зээлийг барагдуулах хүрэлцээ банкны системийн хувьд 101.0 хувь байна.

Зураг 3.4. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.5. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.6. Зээлийн эрсдэлийн сан, чанаргүй зээлийн харьцаа




Эх сурвалж: Монголбанк

Цар тахлын үеийн хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээ нь зарим салбарын чанаргүй зээл буурахад нөлөөлөв.

Нийт чанаргүй зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9 хувиар буюу 107.7 тэрбум төгрөгөөр өссөнд уул уурхайн салбарын чанаргүй зээлийн өсөлт голлон нөлөөлөв. Харин 2022 оны 3 дугаар сард Монголбанкнаас цар тахлын үед хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээ дуусгавар болсон бөгөөд үл хөдлөх (ипотек), худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбар болон хэрэглээ, өрхийн аж ахуйн чанаргүй зээл буурсан нь уг хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний нөлөөлөл тусгагдсан гэж үзэж болох юм (Зураг 3.7).

Тус хөнгөлөлттэй зохицуулалтын дагуу банкууд активт бүтцийн өөрчлөлт хийх, зээл, хүүгийн өр төлбөрийг хойшлуулах, зээлийн ангиллыг хойшлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд хөнгөлөлттэй зохицуулалт дуусгавар болсонтой холбогдуулан банкууд хөнгөлөлтөд хамрагдсан зээлүүдийг бодитоор ангилсан эсэх, харгалзах эрсдэлийн санг тооцоолж, тэнцэлдээ тусгасан эсэхэд хяналт тавьж, улмаар банкны системийн бодит зээлийн эрсдэлийг тодорхойлох зорилгоор **Монголбанкнаас Активын чанарын үнэлгээг гүйцэтгэж байна** (Шигтгээ 5).

Зураг 3.7. Чанаргүй зээлийн үлдэгдэл ба жилийн өсөлт, салбараар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк, ББӨБГ

Шигтгээ 5. Монголбанк Активын чанарын үнэлгээг гүйцэтгэж байна

Банкны салбарт хийгдэж буй шинэтгэлийн цогц арга хэмжээний хүрээнд 2021 онд Улсын Их хурлаар хэлэлцэн баталсан Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй системд нөлөө бүхий банкууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөрт багтаан хувьцаагаа анхдагч зах зээлд арилжиж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээр зохицуулсан. Гэвч цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал болон олон улсад үүссэн цэрэг, улс төрийн хурцадмал нөхцөл байдлын банкны систем болон хөрөнгийн зах зээлд үүсгэж болзошгүй эрсдэлүүдийг харгалзан үзэж, 2022 оны 5 дугаар сарын 10-

ны өдрийн Улсын Их хурлын чуулганы хуралдаанаар энэхүү хугацааг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан.

Системд нөлөө бүхий банкуудын зүгээс дээрх шаардлагыг биелүүлэхэд жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлдээ олон улсын стандартад нийцүүлэн аудит хийлгэх, төлбөрийн чадвар болон актив хөрөнгийн чанарын талаарх мэдээллээ боломжит хөрөнгө оруулагчид, олон нийтэд үнэн зөв мэдээлэх шаардлагатай тул Монголбанкны зүгээс банкууд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс урьдаж олон улсад нэр хүнд бүхий, хараат бус зөвлөх компанийг хөлслөн системд нөлөө бүхий 5 банканд Активын чанарын үнэлгээг гүйцэтгэж байна.

Энэхүү үнэлгээ нь манай улсын банкны системд хийгдэж буй хоёр дахь удаагийн Активын чанарын үнэлгээ бөгөөд Монголбанкнаас баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу хийгдэж байгаагаараа өмнөх 2017-2018 оны Активын чанарын үнэлгээнээс онцлогтой байна.

Банкны тухай хуулийн 43.3, 43.2.13-т тус тус заасны дагуу Монголбанк нь Активын чанарын үнэлгээг гүйцэтгэх зөвлөх компани болох PricewaterhouseCoopers Tax & Advisory LLP, Kazakhstan (цаашид “Зөвлөх” гэх)-ийг сонгон шалгаруулалтын үр дүнд хөлсөлж, 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс Активын чанарын үнэлгээг эхлүүлж, хуанлийн 45 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр ажиллаж байна.

Үнэлгээнд банкны системд нөлөө бүхий 5 банкны нийт активын 69 хувь хамрагдаж байгаа бөгөөд тэдгээрт харгалзах 300-400 ширхэг барьцаа хөрөнгийн үнэлгээ болон үнэлгээний баталгаажуулалт хийгдэж байна.

Монголбанкны зүгээс энэхүү Активын чанарын үнэлгээний үр дүнг эцэслэснээр (1) банкны системд нөлөө бүхий, олон нийтэд хувьцаагаа санал болгох банкуудын үнэлгээ, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтоох, улмаар гадаад, дотоодын оролцогч талуудыг мэдээллийн ил тод байдлаар хангах, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах; (2) Коронавирусын цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний нөлөөллийг тодорхойлох, улмаар банкууд хөнгөлөлтөд хамрагдсан зээлүүдийг бодитоор ангилсан эсэх, харгалзах эрсдэлийн санг тооцоолж, тэнцэлдээ тусгасан эсэхэд хяналт тавьж, банкны системийн нөхцөл байдлыг бодитоор тодорхойлон банкны системийн эрсдэл даах чадвар, Монголбанкнаас цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох; (3) Монголбанкны хяналт шалгалтыг хараат бус, хөндлөнгийн этгээдээр баталгаажуулах чухал ач холбогдолтой.

Эх сурвалж: Монголбанк, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар

Банкны систем дэх Ковид-19 цар тахлын нөлөө

Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай арга хэмжээг дэлхийн улс орнуудын туршлага, банкны болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлсээр ирлээ.

Энэхүү арга хэмжээний хүрээнд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 4.8 их наяд төгрөгийн дүнтэй 134,752 зээл Ковид-19-д өртсөн байгаагаас 71 хувь буюу 3.46 их наяд төгрөгийн 105,693 зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөх нөхцөлд өөрчлөлт оруулаад байна.


Ковид-19-д өртсөн болон өртөж бүтэц өөрчилсөн зээлүүд 2020 оны эцэс хүртэл тасралтгүй өссөөр харгалзан 8.4, 5.4 их наяд төгрөгт хүрээд байсан бол 2021 оноос аажмаар буурсаар 2022 оны эхний хагас гэхэд хамгийн доод хэмжээндээ хүрээд байна. Тодруулбал, 2022 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар Ковид-19-д өртсөн зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар буурч 4.8 их наяд төгрөг болсон бол бүтэц өөрчилсөн зээлийн дүн 33.6 хувиар буурч 3.5 их наяд төгрөгт хүрчээ (Зураг 3.8).

Зээлийн ангиллаар нь авч үзвэл Ковид-19-д өртсөн 4.8 их наяд төгрөгийн зээлийн 68 хувь буюу 3.3 их наяд төгрөгийн зээл хэвийн, 15 хувь буюу 717 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах, 17 хувь буюу 851 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалтай байна (Зураг 3.9).

Түүнчлэн 2022 оны II улирлын дүнгээр аж ахуй нэгжид олгосон нийт зээлийн 21 хувь


буюу 4.9 их наяд төгрөгийн зээл, иргэнд олгосон нийт зээлийн 20 хувь буюу 2.4 их наяд төгрөгийн зээл Ковид-19-д өртжээ. Харин ипотекийн зээлийн хувьд банкны өөрийн эх үүсвэрээр олгосон 258.5 тэрбум төгрөг, МИК-т шилжүүлэхээр хүлээгдэж буй 643.5 тэрбум төгрөг болон МИК-т шилжүүлсэн 1.82 их наяд төгрөг буюу нийт 2.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна.

Зураг 3.8. Ковид-19-т өртсөн зээл болон бүтэц өөрчилсөн зээлийн дүн, тоо



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.9. Ковид-19-т өртсөн зээлийн чанар / их наяд төгрөгөөр, хувиар /



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 3.1. Ковид-19-т өртсөн зээл, төлбөр хариуцагчаар (тэрбум төгрөгөөр, хувиар)

№	Зээлийн төрлөөр	Нийт зээл	Ковид-19-д өртсөн	Нийт зээлд эзлэх %	Бүтэц өөрчилсөн дүн	Бүтэц өөрчилсөн зээл/ Ковид өртсөн зээл
Нийт зээл		23,428	4,851	21%	3,457	71%
1	ААН-ийн зээл	11,449	2,466	22%	1,660	67%
2	Иргэдийн зээл	11,979	2,384	20%	1,797	75%
	Үүнээс: Ипотекийн зээл	3,095	1,218	39%	902	74%
	Ипотек МИК		2,511		1,825	73%

Эх сурвалж: Монголбанк


Банкны салбарын эрсдэлийн үзүүлэлт

Банкны салбарын тоон мэдээлэл болон зохистой харьцааны үзүүлэлтүүдэд тулгуурлан банкны системийн эрсдэлийн нэгдсэн индексийг тооцсон бөгөөд эрсдэлийн нэгдсэн индекс нь **2022 оны II улирлын байдлаар 0.39 болж 2 улирал дараалан буурсан үзүүлэлттэй гарлаа.**


Нэгдсэн индексийн задаргаанаас харвал банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайжирсан, зээлийн эрсдэлийн үзүүлэлт буурсан, харин хөрвөх чадвар болон төвлөрлийн эрсдэлүүд өнгөрсөн оны эцсээс нэмэгдсэн байна (Зураг 3.10, 3.11).

Зээлийн эрсдэл: Засгийн газар, Монголбанкнаас Коронавируст цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн эдийн засгийг сэргээх цогц арга хэмжээний үр дүнд нийт зээлийн нийлүүлэлт өнгөрсөн оноос өсөж чанаргүй зээлийн хувь буурсан үзүүлэлттэй гарсан. Гэсэн хэдий ч олон улсын гео-политикийн хурцадмал байдал болон БНХАУ-ын ковидын эсрэг авч буй хатуу арга хэмжээний үр дүнд гадаад орчны эрсдэл, тодорхой бус байдал нэмэгдсэн нь дотоод эдийн засагт сөргөөр нөлөөлж иргэд, ААН-ийн хувьд төлбөрийн чадвар муудан зээлийн эргэн төлөлт доголдох, улмаар зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна.

Зураг 3.10. Банкны системийн эрсдэлүүд
(Дэд бүлгээр, 2022-6 сар)



Зураг 3.11. Эрсдэлийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 6. Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн


Зээлийн шалгуур: Банкууд 2020 оны эцэс хүртэл ААН-д олгох зээлийн шалгуураа аажмаар чангаруулж байсан бол 2021 оны эхний хагаст хөл хориотой холбоотойгоор бага зэрэг сулруулсан байна. Харин 2022 оны эхний 2 улиралд ААН, иргэдэд олгох зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулжээ. Зээлийн шалгуур чангарахад эх үүсвэрийн зардал нэмэгдсэнээс гадна өрсөлдөөн, тухайн салбарын төлөв, барьцаа хөрөнгийн эрсдэл нэмэгдэж, эдийн засгийн нөхцөл байдал муудсан нь голлон нөлөөлсөн байна. Ирэх 3 сарын хугацаанд банкууд ААН, иргэдийн зээлийнхээ шалгуурыг бага зэрэг чангаруулах төлөвтэй байна.

Зээлийн нөхцөл: Банкууд өнгөрсөн 3 сарын хугацаанд хүүгээ өсгөх, зээлийн хэмжээ, хугацааг бууруулах зэргээр ААН, иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулжээ. Ирэх 3 сарын хугацаанд том, жижиг банкууд ААН-д олгох зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулсан хэвээр байх төлөвтэй байна. Үүнд зээлийн хүүгээ өсгөх, зээлийн хэмжээ, хугацааг бууруулах зэрэг нь голчлон нөлөөлөхөөр хүлээгдэж байна. Дунд банкууд ААН, иргэдийн зээлийн нөхцөлөө өөрчлөх төлөвгүй байна.


Зээлийн эрэлт: Банкны системд өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН, иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн хэвээр байна. ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэхэд эргэлтийн хөрөнгө, зээлийн хүүний ерөнхий түвшин, санхүүжилтийн хэрэгцээ, үндсэн хөрөнгө оруулалт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн. Ирэх 3 сарын хугацаанд ААН, иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэх хэдий ч өмнөх улиралтай харьцуулахад бага зэрэг буурна гэсэн хүлээлттэй байна.

Зээлийн нийлүүлэлт: Зээлийн эрэлт өсөх таамаглалтай уялдуулан том, жижиг банкууд ирэх 3 сард ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг өсгөх төлөвтэй байгаа бол дунд банкууд бууруулах төлөвтэй байна. Иргэдийн зээлийн хувьд жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлж, дунд банкууд бууруулж, том банкууд өөрчлөх төлөвгүй байна.

Зураг 3.12. Зээлийн шалгуурын индекс



Зураг 3.13. Зээлийн эрэлтийн индекс



Эх сурвалж: Монголбанк, Судалгаа статистикийн газар

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2022 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.3 нэгж хувиар буурч 35.5 хувь болсон ч энэ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс 10 нэгж хувь өндөр үзүүлэлт юм. 2021 оны 1 дүгээр улирлаас хэрэгжсэн цар тахлын дараах эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд банкуудын зээл олголт нэмэгдэж, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт багассан нь хөрвөх чадварын үзүүлэлт бага зэрэг муудахад нөлөөллөө.

Ашигт ажиллагаа

2022 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбар 358.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байгаа нь өмнөх оны мөн үеэс 287.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Ингэснээр ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж харгалзан 15.8 болон 1.7 хувьд хүрлээ. Тус оны хагас жилийн байдлаар банкуудад байршуулсан хугацаагүй хадгаламж, харилцахад хүү төлөхгүй байх хуулийн зохицуулалт үргэлж байгаатай холбоотойгоор банкны хүүгийн зардал өмнөх оноос буурсан бол хүүгийн бүс орлогын хэмжээ нэмэгдсэн нь ашигт ажиллагааны үзүүлэлтэд нөлөөллөө.

Зах зээлийн эрсдэл

Гадаад орчны таагүй байдал, гадаад эрэлтийн бууралт, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн савалгаа болон хилийн боомтын хязгаарлалтаас үүдсэн гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн алдагдал нь ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж байна. Ингэснээр банкны салбар дахь эх үүсвэрийн

долларжилтыг өдөөн банкуудын гадаад валютын позицод сөргөөр нөлөөлж эрсдэл хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

Банкны системийн нийт гадаад валютын позицын харьцаа үзүүлэлт 2022 оны II улирлын байдлаар -7.5 хувьтай буюу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа ч төгрөгийн ханш сулралт нь ханшийн алдагдлыг нэмэгдүүлэхээр байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкны системийн хувьд нийт өөрийн хөрөнгө болон 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө хөрөнгийн үзүүлэлт 2022 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар нэмэгдэж 15.5 хувьд хүрсэн буюу зохистой харьцааг ханган ажиллаж байна.


Харин банкны системийн нөлөө бүхий том банкуудад хийгдэж буй Активын чанарын үнэлгээний үр дүнгээр өөрийн хөрөнгийн дутагдал гарвал өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх үүргийг банкууд хүлээнэ. Хэрэв тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлээгүй тохиолдолд тухайн банкны олон нийтэд хувьцаагаа санал болгох (IPO) үйл явц хойшлохоос гадна банкны эрсдэл даах чадвар алдагдаж санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Гадаад актив, пассивын өөрчлөлт


Банкуудын нийт гадаад активын дүн 2022 оны II улирлын байдлаар 3,234 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээтэй байгаа бол гадаад пассив 3,694 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээтэй буюу гадаад актив, пассивын зөрүү 460 тэрбум төгрөгтэй тэнцүү байна.

Банкуудаас гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг улсаар нь харвал Япон улсад 668 тэрбум төгрөг буюу нийт активын 20.7 хувь, Солонгос улсад 521 тэрбум төгрөг буюу 16.1 хувь, БНХАУ улсад 513 тэрбум төгрөг буюу 15.9 хувийг тус тус байршуулжээ. Харин гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн 19.2 хувь буюу 698 тэрбум төгрөгийг Япон улсаас, 16.8 хувь буюу 613 тэрбум төгрөгийг Нидерланд улсаас, 11.6 хувийг буюу 422 тэрбум төгрөгийг ОХУ-аас тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 3.15. Гадаад актив байршуулсан улсаар улсаар (2022.06.30)




Зураг 3.14. Гадаад актив, пассивын өөрчлөлт, /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.16. Гадаад пассив байршуулсан улсаар



Эх сурвалж: Монголбанк, ББӨБГ

Газар зүйн байршлаас хамаарсан эх үүсвэрийн төвлөрөл харьцангуй бага байна. Гадаад актив, пассивыг улсаар нь авч үзэхэд аль нэг улсад байршуулсан болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн хамгийн ихдээ 20.7 хувь байгаа нь үүнийг харуулж байна.

Олон улсад үүссэн геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын зарим банкуудад тодорхой хязгаарлалтууд тавигдсанаар тус улс руу хийгдэж буй төлбөр

тооцоо саатах, түгжигдэх, хоцрох зэрэг эрсдэлүүд банкуудад тулгарсан.

Иймд банкуудын зүгээс тус эрсдэлийг бууруулахын тулд ОХУ-д байршуулсан мөнгөн хөрөнгийн хэмжээгээ бууруулах хандлагатай байна. Тухайлбал ОХУ-ын банк, санхүүгийн байгууллагад 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 75.6 тэрбум төгрөг байршиж байсан бол 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 86.5 хувиар буурч, 10.2 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээтэй болсон байна.

Харин ОХУ-аас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн өмнөх улирлаас 112 тэрбум төгрөгөөр буюу 20.9 хувиар буурчээ (Зураг 3.17).


Мэдээллийн технологийн эрсдэл

Банкуудын мэдээллийн технологийн эрсдэлийн түвшинг тогтоох зорилгоор 2022 оны II улирлын байдлаар (i) кибер эрсдэл, (ii) интернет банкны эрсдэл, (iii) мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, (iv) мобайл банкны эрсдэл, (v) төлбөрийн систем болон холбогдох дэд бүтцийн эрсдэл, (vi) МТ-ийн бүтээгдэхүүн нийлүүлэгчийн эрсдэл гэсэн бүлгүүдийн хүрээнд асуулга бэлтгэж, тоон болон чанарыг мэдээллийг банкуудаас цуглуулсан. Бүлэг тус бүрийн хувьд [1;5] гэсэн утгуудыг оноож эрсдэлийн түвшинг тодорхойлов (Зураг 3.18).

Банкуудын хувьд 2022 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар кибер эрсдэл, интернет банкны эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, төлбөрийн систем болон холбогдох дэд бүтцийн эрсдэл дундаас бага, мобайл банкны эрсдэл, МТ-ийн бүтээгдэхүүн нийлүүлэгчийн эрсдэл бага гэсэн үнэлгээтэй байна.


Түүнчлэн банкуудад мэдээллийн технологийн чиглэлээрх хүний нөөцийн дутагдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, системийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж саатал үүсэх, сүлжээ тасрах, цахим халдлага гэх мэт мэдээллийн технологийн (МТ)-ийн эрсдэлүүд нийтлэг тулгарч байгаа бөгөөд банкуудын зүгээс эдгээр эрсдэлүүдийг бууруулахын тулд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Зураг 3.17. Гадаад актив, пассивын өөрчлөлт /тэрбум төгрөг, ОХУ/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.18. 2022 оны 6 дугаар сарын байдлаар банкуудын МТ-ийн эрсдэлийн түвшин



Эх сурвалж: Монголбанк


Шигтгээ 7. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн түүвэр судалгаа

Монголбанкны захиалгаар Монголын эдийн засгийн шинжилгээ судалгааны төв ТББ нь 2021 оны 12 дугаар сарын 13-30-ны өдрүүдэд нийт 11 банкны эрсдэлийн удирдлага эрхэлсэн удирдлагуудаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, “Арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнгээр арилжааны банкууд 2022 оны эрсдэлийн нөхцөл байдал, хүлээлтийг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:

- **Банкуудын зээл, хадгаламж, ашигт ажиллагаа:** Банкуудын ашигт ажиллагаа нь 2022 онд өмнөх онтой харьцуулахад сайжирна гэсэн хүлээлттэй байна. Ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд 2022 онд бүх арилжааны банкууд зээл олголтоо дунджаар 12 хувиар өсгөхөөр төлөвлөсөн бөгөөд иргэдийн зээлийн өсөлт нь бизнесүүдэд олгох зээлийн өсөлтөөс бага зэрэг илүү байна гэж таамаглажээ. 2021 онд ипотекийн зээлийн санхүүжилт эрчимтэй нэмэгдсэн нь иргэдийн зээлтэй холбоотой хүлээлтийн хандлагыг өөрчилжээ. Харин хадгаламжийн хэмжээгээ өмнөх онтой харьцуулахад том банкууд дунджаар 10 хувиар, дунд банкууд 5 хувиар, жижиг банкууд 36 хувиар нэмэгдүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд үйл ажиллагааны зардлаа бууруулахдаа өдөр тутмын ажлаа илүү автоматжуулж, цахимжуулахаар төлөвлөжээ.
- **Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн хувьд** хүлээлт өмнөх онтой харьцуулахад муудсан нь төгрөгийн ханшийн сулралт банкуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, үл хөрөнгийн хөрөнгийн үнэ өснө гэж таамагласантай холбоотой юм. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийг 2022 онд өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 3-5 хувиар суларна, үл хөдлөх хөрөнгийн үнэ дунджаар 5 хувиар өснө гэсэн хүлээлттэй байв.
- **Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд** том хэмжээний банкууд хөрвөх чадвар буурахгүй байх боломжтой гэж үзсэн бол бусад банкуудын хувьд банкны хэмжээ бага байх тусам хөрвөх чадварын эрсдэл харьцангуй өндөр байна гэсэн хүлээлттэй байна.
- **Үйл ажиллагааны эрсдэлийн хувьд** эрсдэл учруулагч хамгийн том хүчин зүйлээр кибер эрсдэлийг дахин нэрлэж үүний дараа орох томоохон эрсдэлийг луйвар болон залилангийн хэргүүд гэж үзжээ. Банкны эрсдэлийг дотооддоо үнэлэхэд учрах бэрхшээлийг 2021 онд хууль, эрх зүйн орчны өөрчлөлт гэж нэрлэж байсан бол 2022 онд эдийн засгийн шок, гадаад хүчин зүйлсийн өөрчлөлт гэж нэрлэжээ.
- **Макро эдийн засгийн эрсдэл:** 2022 онд макро эдийн засагт гарах өөрчлөлтүүдийн банкны үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн хүлээлт өмнөх онтой харьцуулахад сайжирлаа. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад нэмэгдэнэ гэж таамаглаж байгаа бол Монгол улсын зээлжих зэрэглэл өөрчлөгдөхгүй гэж үзжээ.
- **Гадаад эрсдэлийн хувьд** 2022 оны хүлээлт 2021 оныхтой харьцуулахад бага зэрэг сайжирсан хэдий ч эрсдэл өндөр хэвээр байна. Ийнхүү эрсдэл өндөр байхад цар тахлын вирусын шинэ хувилбаруудын дэгдэлт, импортын өндөр хамаарал, нийлүүлэлтийн саатал зэрэг нь нөлөөлнө гэж үзжээ. Мөн гадаадаас санхүүжилт авах боломж дунд зэрэг гэж хүлээж байна.
- **Зээлийн чанарын хувьд** банкуудын 55 хувь нь бага зэрэг муудна, 27 хувь нь өөрчлөлт гарахгүй гэсэн хүлээлттэй байв. Активын чанарыг сайжруулах хамгийн түгээмэл арга нь шүүхийн бүс журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох гэж ихэнх банк үзэж байна. Тухайлбал чанаргүй активыг шийдвэрлэхэд тулгарч буй гол бэрхшээл нь шийдвэрлэх хугацаа хэт урт, шат дарааллын хувьд нарийн, түвэгтэй гэж хариулжээ. Чанаргүй активын хэмжээг өсгөсөн голлох шалтгаанаар цар тахлын үеийн нөхцөл байдал, зохицуулалт, макро эдийн засгийн орчин муудсан нь гэж тодорхойлжээ.

- Ерөнхийд нь 2022 оны банкуудын хүлээлтээс харахад банкны эрсдэлд нөлөөлөх нөхцөл байдлыг өмнөх оноос бага зэрэг сайжрахар таамагласан бөгөөд үүнд Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийн үргэлжлэх хугацааг харьцангуй богино байхаар үнэлсэн нь нөлөөлжээ. Гэвч үйл ажиллагааны хувьд хамгийн том эрсдэлийг цар тахлын нөхцөл байдал, зохицуулалтаас үүдэлтэй зээлийн чанар муудах эрсдэл гэж арилжааны банкууд дүгнэв. Мөн энэ нь арилжааны банкуудын сүүлийн жилүүдийн активын чанар муудахад нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл болсон гэж үзсэн байна.

Зураг 3.19. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Эрсдэлийн дундаж үнэлгээ (1-маш өндөр, 2-өндөр, 3-дундаж эрсдэлтэй, 4-бага, 5-маш бага гэсэн утгатай)

3.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.2.1 Үнэт цаасны салбар


Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны мэдээллээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар 4,841.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 3.19). Үнэт цаасны арилжааны тухайд тайлант хугацаанд арилжаалагдсан үнэт цаасны 41.2 хувийг хувьцаа, 36.9 хувийг компанийн бонд, 21.0 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 0.9 хувийг хөрөнгө оруулалтын сан тус тус эзэлж байна. Нийт арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 2.3 дахин бүүрч 275.9 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна (Зураг 3.20).

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас тооцдог хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилдаг ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 713.3 нэгжээр буюу 2.1 хувиар буурч 32,795.7 нэгж болов (Зураг 3.21).


“Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-ын дагуу 2018 оны 02 дугаар сараас эхлэн үнэт цаасны бүртгэлийн I болон II дугаар ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

Тайлант хугацаанд MSE A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,860.1 нэгжээр буюу 17.7 хувиар өсөж 12,384.7 нэгж болсон. Харин MSE B индексийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.0 нэгжээр буюу 0.2 хувиар өсөж 11,450.93 нэгж болсон (Зураг 3.21).


Зураг 3.19. Зах зээлийн үнэлгээ, эхний хагас жилийн байдлаар /их наяд төгрөг/



Зураг 3.20. Үнэт цаасны арилжаа, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Зураг 3.21. MSE A, MSE B, ТОП–20 индекс /хаалтын ханш, сараар/



Цар тахлын үеийн бодлогын арга хэмжээнүүд нь иргэдийн хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүллээ. Монгол Улсын хувьд цар тахлын үед 2020 оны 3 сараас эхлэн бодлогын хүү 6.0 хувь хүртэл буурсан. Мөн төрөөс иргэдийн НДШ-ийг тэглэх, ипотекийн зээл төлөлтийг хойшлуулах, хэрэглээний үс, цахилгаан, дулааны үнийг төлөх зэрэг арга хэмжээ авсан. Монгол Улсад төдийгүй дэлхий даяар энэ мэт цар тахлын эсрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн нь иргэдийн хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж, орон зайг бий болгосон.

Үүний нөлөөгөөр Монгол Улсын Хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 2021 онд анх удаа 6.0 их наяд төгрөгт хүрч, ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 130.3 хувиар өсөж 44,411.6 төгрөгт хүрсэн. Түүнчлэн нийт 1.4 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21.6 дахин өссөн үзүүлэлт юм.

Гэвч геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалан дэлхийн хөрөнгийн зах зээл уналтад орж эхлэв. 2022 оны 2 дугаар сарын сүүлээс эхлэн ОХУ нь Украин улс руу довтолж, хурцадмал байдал үүсгэсэн нь дэлхий нийтийг цочирдуулж, эдийн засаг, санхүүгийн сөрөг үр дагавар, тогтворгүй байдлыг үүсгэж байна. Улмаар 2022 оны 2 дугаар сарын байдлаар олон улсын хөрөнгийн зах зээл ерөнхийдөө уналтад орж эхэлсэн. Жишээлбэл, АНУ-ын S&P 500 индекс 3.1 хувиар, NASDAQ нийлмэл индекс 3.4 хувиар, Dow Jones индекс 3.5 хувиар, Nikkei 225 индекс 1.8 хувиар тус тус унасан байна.

Олон улсын байгууллагуудаас 2022 он цар тахлын 2 жилтэй харьцуулахад харьцангуй эерэг өсөлттэй жил болно гэж тооцоолсон

боловч ОХУ ба Украины нөхцөл байдал газрын тос, байгалийн хий, улаан буудай зэрэг түүхий эдийн үнэд нөлөө үзүүлж буй нь хөрөнгийн зах зээлд дахин тогтворгүй байдлыг авчрах магадлалтай юм.


3.2.2 Даатгалын салбар

Даатгалын зах зээлд нийт хөрөнгөөрөө эхний 5-д жагсаж байгаа даатгалын компанийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үед нийт зах зээлийн 55.0 хувийг эзэлж байсан бол тайлант улиралд 52.1 хувь болж буурчээ.


Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 431.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Харин нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.8 хувиар буурч 185.9 тэрбум төгрөгт хүрлээ (Зураг 3.22).

Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 48.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс 66.1 хувиар өссөн дүн юм (Зураг 3.23).

Зураг 3.22. Даатгалын салбарын нийт хөрөнгө, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Зураг 3.23. Даатгалын нөхөн төлбөр, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 124.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлсний 98.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус төвлөрүүлсэн бөгөөд даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн байна (Зураг 3.24).

Зураг 3.24. Даатгалын хураамж, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Даатгалын зах зээлийн бүтэц

Тайлант үед нийт 329 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2426 даатгалын төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 3.2. Даатгалын зах зээлийн оролцогчид

№	Даатгалын зах зээлийн оролцогчид	2022 оны 2 дугаар улирал
1	Даатгалын компанийн тоо	17
2	Үүнээс: ердийн даатгалын компани	15
3	Үүнээс: урт хугацааны даатгалын компани	1
4	Үүнээс: давхар даатгалын компани	1
5	Даатгалын зуучлагч компанийн тоо	62
6	Даатгалын хохирол үнэлэгч компанийн тоо	25
7	Аудитын компанийн тоо	43
8	Аудиторын тоо	144
9	Актуарчийн тоо	38
10	Даатгалын төлөөлөгчийн тоо	2,426

Эх сурвалж: СЗХ

3.2.3 Банк бус санхүүгийн байгууллагын салбар

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 527 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 83.1 хувь нь Улаанбаатар хотод байршдаг. Нийт ББСБ-уудын 92.7 хувь буюу 489 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Зураг 3.25).

ББСБ-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тухайлбал нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улиралд 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар, нийт зээлийн хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 58.9 хувиар тус тус өссөн байна. Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.7 сая хүрч өмнөх оны мөн үеэс 44.2 хувиар өсөж, зээлдэгчдийн тоо 1.5 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 102.1 хувиар өслөө (Зураг 3.26).

Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 72.8 болон 91.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.


Анхаарах шаардлагатай асуудлууд

Мөн томоохон эдийн засгууд инфляцыг бууруулах хүрээнд мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж байгаа нь хөгжиж буй эдийн засгуудаас гадагшлах хөрөнгийн үрсгалыг нэмэгдүүлж болзошгүй байна. Цаашид ОХУ-Украины нөхцөл байдал хурцдаж геополитикийн тогтворгүй байдал удаан үргэлжлэх, Коронавируст халдварын (Ковид-19) мутацид орсон шинэ хувилбарууд дахин тархах, инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж болзошгүй байна.

Цахим шилжилтийн эрин үед үйлчилгээний түгээлтийн суваг, хэрэглэгчийн чиг хандлага өөрчлөгдөж, хамгийн хялбараар, түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болсон ба санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд бий болж, ББСБ-ын салбар хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн үйл ажиллагаатай уялдан олон тулгуурт санхүүгийн үйлчилгээ хөгжиж байна. Иймд Банк бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү гүнзгийрүүлж, олон тулгууртай болгох замаар эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэхэд анхаарч, салбарын онцлог, бүтээгдэхүүн, үйлчилгээнд


нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлыг идэвхжүүлэх шаардлага тулгарч байна.

Зураг 3.25. ББСБ-ын тоо ба харилцагчид, эхний хагас жилийн байдлаар




Эх сурвалж: СЗХ

Зураг 3.26. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Зураг 3.27. ББСБ-ын зээлийн чанар, эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: СЗХ

Технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч

үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар иргэдэд хүрэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн, төрөөс үзүүлж буй тусгай зөвшөөрлийн тоог бууруулсан, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлсэн хууль эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй нөхцөл байдал банк бус санхүүгийн салбарт тулгараад байна.


3.2.4 Хадгаламж, зээлийн хоршооны салбар

2022 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-дын тоо өмнөх онтой харьцуулахад 34-өөр буюу 14.5 хувиар буурч 200 ХЗХ болсон байна. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо 73,719 байсан бол тайлант үед 1.56 хувиар буурч 72,566 гишүүн болжээ. Тайлант улиралд нийт 200 ХЗХ-ноос 110 ХЗХ нь Улаанбаатар хотод, 90 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна. Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 6.4 сая төгрөгийн зээлтэй байна. Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 9.6 сая төгрөг байгаа бол орон нутагт 2.8 сая төгрөг байна.

Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 0.42 хувиар өсөж 271.6 тэрбум төгрөгт хүрлээ (Зураг 3.28). Харин нийт зээлийн хэмжээ 217.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өслөө. Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өсөж 212.2 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 11.8 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөгт хүрлээ. Тайлант үед хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсөж 204.9 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн


хэмжээ 10.0 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн хэмжээ 4.7 хувиар нэмэгдэж 7.2 тэрбум төгрөгт тус тус хүрлээ (Зураг 3.29).

Зураг 3.28. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө, хадгаламж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Зураг 3.29. Зээлийн чанар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Нийт олгосон зээлийн 66.2 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 10.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна. Нийт эргэн төлөгдсөн зээлийн 70.5 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар олгосон зээлээс, 9.3 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 5.0 хувь нь хөдөө аж ахуйн салбараас эргэн төлөгдсөн байна. Нийт зээлийн 94.1 хувийг хэвийн, 2.6

ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буурч 189.4 тэрбум төгрөг боллоо (Зураг 3.31). Харин хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү 1.22 хувь, зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.12 хувь байна (Зураг 3.32).

- ХЗХ-дын өмнөх тохиолдлуудын улмаас иргэдийн итгэл суларсан;
- Иргэдийн санхүүгийн харилцаан дахь эрх ашгаа хамгаалах мэдлэг муу;
- Финтекийн компаниуд зах зээлд ихээр нэвтэрч, харилцагчдын тоо огцом нэмэгдэж байгаатай холбоотой ХЗХ-дын зах зээл хумигдаж болзошгүй;
- Найдваргүй зээлийг барагдуулах эрхзүйн орчин чирэгдэл ихтэй;
- 4 ХЗХ буюу 1.8 хувь нь салбарын нийт хөрөнгийн 64 хувийг бүрдүүлдэг ба хөрөнгийн төвлөрөл өндөр байна.

- Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, тогтворжилтын сан, дундын санхүүгийн байгууллага байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд зах зээлийн чиг хандлагад тохирсон зохицуулалтыг бий болгох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож шинэчлэх;

Year	Хэвийн бүс (%)	Эргэлзээтэй зээл (%)	Мүү зээл (%)
2018.II	45.3%	38.1%	16.6%
2019.II	28.3%	19.0%	52.7%
2020.II	34.8%	18.3%	46.9%
2021.II	29.2%	19.8%	51.0%
2022.II	25.07%	17.75%	57.17%

Хугацаа	Нийт хадгаламж /тэрбум төгрөг/	Хадгаламжийн өсөлт
2018.II	124.5	51.6%
2019.II	148.4	19.2%
2020.II	163.4	10.1%
2021.II	191.2	17.0%
2022.II	189.4	-0.9%

Period	ЗЖДХ (Average)	ХЖДХ (Average)
2019.IV	3.4	1.6
2020.I	3.1	1.5
2020.II	2.9	1.5
2020.III	2.85	1.5
2020.IV	2.98	1.5
2021.I	2.4	1.4
2021.II	2.46	1.4
2021.III	2.2	1.4
2021.IV	2.2	1.2
2022.I	2.1	1.1
2022.II	2.12	1.2

- Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийг банкны адилаар албан

журмын даатгалд хамруулах эрх зүйн орчин бий болгох;

- Тусгай зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой асуудал, хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгуурласан эргэх холбоо бүхий үйл ажиллагааны нэгдсэн системийг үе шаттай нэвтрүүлэх, мэдээллийн бааз бүрдүүлэх, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт болон төрийн бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох боломжийг нээх;
- Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж хоршоодыг бүрэн хамруулах;
- Зохицуулалтын салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын журам, аргачлалыг олон улсын стандарт, засаглалын зарчимтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах.

3.2.5 Виртуал хөрөнгийн зах зээл

Нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд, ялангуяа 2021 оноос төвлөрсөн бус системд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ дэлхийн зах зээлд хүчээ авч уламжлалт санхүүгийн систем хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж, виртуал хөрөнгийн үйлчилгээ Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд мөн адил өргөн тархав. Үүний үр дүнд төвлөрсөн бус, дундын зуучлагчгүй, зардал багатай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээс сонгон хэрэглэх боломжтой болсон.

Гэвч нөгөө талаар дээрх давуу талууд нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийг их хэмжээгээр нэмэгдүүлэв. Энэхүү үйлчилгээг нууцлалтайгаар, түргэн шуурхай, бага

зардалтай дундын зуучлагчгүй авах боломжтой болсон нь нөгөө талаас цахим гэмт хэрэг, мэдээллийн нууцлалыг алдагдуулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эдийн засгийн гэмт хэрэгт өртөх, ашиглуулах эрсдэлүүдийг бий болгосон. Түүнчлэн виртуал хөрөнгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь ил тод бус, төвлөрсөн бус системд суурилдаг учраас гэмт хэргээс үүдэж олсон хөрөнгийг нуун далдлах, эргэлдүүлэх, хөрөнгийн жинхэнэ гарал үүслээс холдуулах боломжтой тул аюул занал, эмзэг байдал өндөртэй байна.

Монгол Улсад дэлхий дахинд өргөн тархаж буй блокчэйн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ 2021 оны 8 дугаар сараас өргөн дэлгэрч виртуал хөрөнгийн арилжааны платформ үүсэж, койн гаргаж, олон нийтээс хөрөнгө татахын зэрэгцээ иргэд, олон нийт үүнд хөрөнгө оруулах сонирхол улам нэмэгдэж байна.

2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 63 койн/токен зах зээлд арилжаалагдаж, 970.1 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн тухай мэдээллийг холбогдох биржүүд ирүүлсэн бөгөөд 25 койныг зах зээлд гаргахаар бэлтгэж байна. Түүнчлэн давхардсан тоогоор 23 криптовалютын арилжааны платформ үйл ажиллагаагаа явуулж байгаа бол 5 платформыг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна. Дотоодын арилжааны платформууд дээр нийт 8-10 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн гэж таамаглаж байгаа бөгөөд зах зээл дээр нийт 75 төрлийн NFT, 11 NFT marketplace, 63,959 NFT арилжаалагдаж байна.

Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй криптовалютын 5 бирж давхардсан

тоогоор 707,826 иргэдэд үйлчилсэн байгаа бөгөөд тус биржүүдийн арилжааны шимтгэл 0.05 хувиас 0.5 хувьтай байна. Одоогийн байдлаар улсын хэмжээнд 11 төрлийн токен гарахаар, 5 криптовалютын бирж байгуулагдахаар хүлээгдэж байна.

Криптовалютын зах зээлд санхүүгийн төрөл бүрийн эрсдэл үүсэх боломжтой. Иймд хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс зохицуулалтын арга хэмжээг авах шаардлага үүсэж байна. Ингэснээр:

1. Хөрөнгө оруулалт хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг гэх мэт хууль бус үйл ажиллагаанд зориулагдахаас хориглох;
2. Санхүүгийн гүйлгээ нь ил тод буюу татвараас зугтаагаагүй эсэхийг нягтлах;
3. Үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах боломжтой болно.

Тулгарч буй эрсдэл, эмзэг байдал, цаашдын сорилтууд

Виртуал хөрөнгө эзэмшиж буй иргэд, байгууллагын тоо сүүлийн жилд огцом өсөж, виртуал хөрөнгө, бодит эдийн засаг хоорондын холбоо хамаарал нэмэгдэж байгаагаас шалтгаалж санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогод үзүүлэх нөлөө ч тодорхой хэмжээгээр өсөж байна. Виртуал хөрөнгө энэхүү өсөлтөд хэрхэн нөлөөлсөн тухай нарийвчилсан судалгаа байхгүй хэдий ч олон улсын жишиг, хандлагаас харахад иргэдийн виртуал хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалт, ашиглах хандлага нэмэгдэж байгаа тул далд эдийн засагт мөн тодорхой хэмжээгээр ашиглагдах боломжтой.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн дийлэнх хувийг арилжааны банк бүрдүүлж байгаа бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь энэхүү зохицуулалтай салбараас бүрэн хамааралтай үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болох юм. ВХҮҮ-дээс авсан судалгаанаас харахад иргэд, байгууллага виртуал хөрөнгө худалдаж авах, арилжих тохиолдолд өөрийн банкны дансыг ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой бөгөөд харин виртуал хөрөнгийг виртуал хөрөнгөөр арилжих үйл ажиллагаа хязгаарлагдмал байна.


Иргэдийн дундах виртуал хөрөнгөтэй холбоотой мэдлэг, мэдээлэл дутуу, үүсэж болох эрсдэлийг бүрэн ойлгоогүй байгаа тул гэмт хэргийн хохирогч болох, аливаа залилан луйварт өртөх магадлал өндөр хэвээр байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад журмаар **виртуал хөрөнгийг төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах нь хориотой үйл ажиллагаа** тул одоогоор виртуал хөрөнгийн зах зээл нь санхүүгийн зах зээлтэй бүрэн интеграцчилагдах боломж байхгүй гэж үзэж байна.

Шигтгээ 8. Эдийн засгийн өсөлтийн эрсдэлийн шинжилгээ

GaR аргачлалаар өнөөгийн санхүүгийн систем болон зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн ирээдүйн тархалтад хэрхэн нөлөөлөхийг тооцдог. Өөрөөр хэлбэл, санхүүгийн үзүүлэлтүүдийн нийтлэг хөдөлгөөнийг илэрхийлэх тайлбарлагч хувьсагчдыг статистик аргачлалаар ялган авч, тэдгээрийн өөрчлөлтийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх эрсдлийг квантил регресс (quantile regression)-ийг ашиглан тооцдог. Энэ аргачлал нь эдийн засгийн өсөлтийн цэгэн үнэлгээнээс гадна тархалтад гарах өөрчлөлтийг судалдаг тул санхүүгийн системийн өөрчлөлтөөс шалтгаалан эдийн засагт эрсдэл нэмэгдэж буй эсэхийг тодорхойлох боломж олгоно. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахад 1) Санхүүгийн нөхцлийн индекс, 2) Эмзэг байдлын индекс 3) Бусад (Гадаад нөхцөл байдлыг илэрхийлэх хувьсагчид) фактор бүлгүүдийг (factor partition groups) үүсгэж, үнэлгээнд ашиглав. Ирэх жилийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийн суурь хувилбарын мүүд утга 5.9 хувь, медиан утга 4.1 хувь байна. Харин зээл олголт тасалдаж, зээлийн өсөлт 11 нэгж хувиар саарахад суурь төсөөллөөс мүүд утга 3.2 нэгж хувиар, медиан утга 0.7 нэгж хувиар буурч 2.7 хувь, 3.4 болж байна.

Зураг 3.33. Эдийн засгийн өсөлтийн тархалт, 2023 он



Хүснэгт 3.3. Үнэлгээнд ашигласан хувьсагчид

2023 он		
	Суурь	Зээлийн өсөлт ↓
Мүүд утга	5.9	2.7
Медиан	4.1	3.4
Өсөлт <0% магадлал	21.2%	22.4%

Эх сурвалж: Монголбанк

4. Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

4.1 БАНКНЫ САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

4.1.1 Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд

Олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, бусад төв банкуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судлан үзээд өөрийн орны онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ нь олон улсын сайн туршлагатай нийцтэй бөгөөд санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг буурууллаа.

1. Зээлдэгчдэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээнүүд:

Монголбанкнаас цар тахалтай холбоотойгоор зээлдэгчдэд үүсэж буй дарамтыг бууруулах зорилгоор дараах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв. Үүнд:

- Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зориулалтаар иргэнд олгосон зээлийн ангилал бууруулах хугацааг уртасгах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх;
- Бүх төрлийн зээлд бүтцийн өөрчлөлт хийхэд хязгаарлалтгүй болгох;
- Эргэн төлөлтийн хүндрэлд орсон иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг сунгах боломжийг олгох;
- Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хүү болон үндсэн төлбөрийг түр хугацаагаар хойшлуулах.


Банкуудад мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаанд өөрчлөлт оруулсан юм. Тухайлбал, зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгов. Дээрх зохицуулалтуудыг 2021 оноос эхлэн хэвийн горим руу шилжүүллээ.

2. Санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлж, зээлийн тасалдлаас сэргийлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүд:

Цар тахлаас шалтгаалан зээлийн өсөлт огцом саарвал **эдийн засгийн өсөлт хурдацтай буурахаар байв**. Тухайлбал зээлийн өсөлт саарах нөхцөлд эдийн засгийн өсөлт 4 улирлын дараа хэрхэн өөрчлөгдөхийг Growth-at-Risk (GaR) аргачлалаар тооцоолж байсан бөгөөд ААН-ийн зээлийн жилийн өсөлт 20 нэгж хувиар (тухайлбал, жилийн 20 хувиар өсөхөөр төсөөлсөн зээлийн өсөлт 0 хувь болох) буурвал эдийн засгийн өсөлт 2.9 хувиар, зээлийн жилийн өсөлт 45 хувиар саарвал эдийн засгийн өсөлт 6.7 хувиар буюу огцом буурахаар байв. (Зураг 4.1) Иймд санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлж, зээлийн тасалдлаас сэргийлэх арга хэмжээнүүд нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг

гүйцэтгэв. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт 0-ээс бага болох магадлал дээрх хоёр хувилбарын хувьд 1 хувиас харгалзан 9 хувь, 62 хувь болж нэмэгдэв.

Зураг 4.1. Эдийн засгийн өсөлтийн тархалт, 4 улирлын дараа



Эх сурвалж: Монголбанк, СТБ3-ийн хурал 2019.12 сар

Бодлогын хүүг түүхэн доод түвшин (6%-д хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалав. Тус шийдвэр нь КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэв. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн хүү 2019 оны 12 сард 16.9 хувь байсан бол 2021 оны төгсгөлд 14.3 хувьд хүрч түүхэн доод түвшинд хүрэв. Нөгөө талд, шинээр татсан хадгаламжийн дундаж хүү 2019 оны 12 сард 10.5 хувь байсан бол 2021 оны эцэст 5.8 хувьд хүрч буурлаа (Зураг 4.2).

Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулж, 2021 оныг дуустал хэвээр хадгалав. Мөнгөний бодлогын хүрээнд төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 2020 онд 4.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх, хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар тогтоох, жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх,

санхүүжилтийн хэмжээг тогтоох зэрэг багц шийдвэрийг гаргав. ЗБН-ийн хувийг ийнхүү бууруулснаар 700 гаруй тэрбум төгрөг ЗБН-өөс чөлөөлөгдөв.

Зураг 4.2. Хүүний түвшин



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү шийдвэр нь цар тахлын үед банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, банкны зээлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих зорилготой байв.

Аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 2021 оны 2 сард Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г батлав. Тус төлөвлөгөөний хүрээнд хөнгөлөлттэй хүүтэй зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд аж ахуйн нэгж, иргэд, малчдад санхүүгийн дэмжлэг болж, бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засаг дахь төлбөрийн чадварын хүндрэлээс сэргийлэх зорилготой байв. Уг хөтөлбөрийн хүрээнд буюу ажлын байрыг дэмжих, репо санхүүжилт, ипотека, хөдөө аж ахуйн зээлийн хүрээнд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 67,564

зээлдэгчид 5.19 их наяд төгрөгийн санхүүжилт олгов. Үүнийг эх үүсвэрийн бүтцээр авч үзвэл 48.1 хувь нь Монголбанкны эх үүсвэртэй бол үлдсэн 51.9 хувь нь банкуудын эх үүсвэртэй байлаа (Хүснэгт 4.1).

Тус төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хувьд авч үзвэл 56 арга хэмжээний 25 арга хэмжээг 2021 онд, 3 арга хэмжээг 2021-2022 онд, 17 арга хэмжээг 2021-2024 онд, 11 арга хэмжээг халдвар тархалтын шаталсан түвшин, нөхцөл байдлаас хамаарч тухай бүрд нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ажлын байрыг дэмжих болон урт хугацааны репо санхүүжилтийн хүрээнд 2021 онд олгосон нийт санхүүжилтийн 43 хувийг нь бөөний болон жижиглэнгийн салбарт, 18 хувийг үйлчилгээний бусад салбарт олгожээ. Харин дэмжлэг үзүүлсэн нийт 146 мянган ажлын байрны 35 хувь буюу 50,708 ажлын байрыг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 19 хувь буюу 27,131 ажлын байрыг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 13 хувь буюу 19,289 ажлын байрыг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7 хувийг барилгын салбарт, бусад эдийн засгийн салбарт 19 хувь буюу 27,598 ажлын байрыг дэмжиж зээл олгосон байна.⁴

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд зээлийн өсөлт сэргэж, бодит секторыг шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээр хангаж, эдийн засгийн сэргэлтэд эерэгээр нөлөөллөө. 2021 он гарснаас хойш дэлхий дахинд эдийн засаг, санхүүгийн зах зээл сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсч, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарч, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийн олголт нэмэгдсэнээр манай


улсын санхүүгийн мөчлөг тэнцвэрт түвшингээс илүү сэргэж эхлэв (Зураг 4.3).

Хүснэгт 4.1. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, 2022 оны эхний хагас жилийн байдлаар

Зээл, санхүүжилтийн хөтөлбөр	Зээлийн дүн		Зээлдэгчийн тоо
	Төлөвлөгөө тэрбум ₮	Биелэлт тэрбум ₮	
А. Арилжааны банкны эх үүсвэр, хүүний татаас	2,880.0	2,695.5	
Ажлын байрыг дэмжих зээл	2,000.0	1,962.7	25,499
Хөдөө аж ахуйн зээл	880.0	732.8	22,075
Б. Монголбанкны эх үүсвэр	4,000.0	2,498.2	
Урт хугацаат репо санхүүжилттэй зээл	2,000.0	1,214.7	3,581
Орон сууцны ипотекийн зээл	2,000.0	1,283.5	16,409
Нийт	6,880.0	5,193.7	67,564


Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.3. Санхүүгийн мөчлөг (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.4. Зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

⁴ Эх сурвалж: “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн - 2021” тайлан, Монголбанк (2022)

Тухайлбал банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өссөн дүнтэй байна (Зураг 4.4).

3. Банкны ашигт ажиллагаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд:

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулах, өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түр хугацаанд түдгэлзүүлэх шийдвэрийг гаргаснаар банкуудын санхүүгийн чадавхад эерэг нөлөө үзүүлэв. Түүнчлэн цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 онд Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зарим зохицуулалтыг сулруулсан ба 2021 оноос эхлэн хэвийн горим руу шилжүүлээ.


Бодлогын арга хэмжээний үр дүнд банкны ашигт ажиллагаа, ТТГЧ, төлбөрийн чадвар сайжрав. Тухайлбал чанаргүй зээл, анхаарал хандуулах зээлийн хувь хэмжээ 2021 онд эрчимтэй буурав (Зураг 4.5). Аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор 10 их наядын хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг дахь төлбөрийн чадварын хүндрэлээс сэргийлэв.

Санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараалан хэрэгжүүлснээр **хадгаламжийн долларжилт 2020 оны 4 дүгээр улирлаас эхлэн 2022 оны эхний улирал хүртэл эрчимтэй буурав** (Зураг 4.6). Цар тахлын үеийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв, эрсдэлийг харгалзан банкны эх үүсвэрийн долларжилтыг

бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор дараах арга хэмжээг авав. Үүнд:


- Гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэх;
- Гадаад валютын хадгаламжийг албан даатгалд хамруулахгүй байх;
- Иргэн хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хязгаарлах;
- Өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын дүнгээс хамааруулан ЗБН-ийн урамшууллыг бууруулах арга хэмжээ.

Зураг 4.5. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.6. Зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

4.1.2 Геополитикийн зөрчил, гадаад эдийн засгийн сөрөг нөлөөллийн үеийн арга хэмжээнүүд (2022 он)

2022 оны эхнээс олон улсын харилцаанд хурцадмал байдал шинээр үүсэж, гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдал огцом нэмэгдсэн нь инфляц, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, хүнсний үнэ огцом өсөж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжилсэн нь дотоодын инфляц өмнө нь төсөөлж байснаас нэмэгдэх, эдийн засгийн өсөлт саарах үр дагавар бий болгов.


Шатахуун, хүнс болон импортын барааны үнийн өсөлт инфляцыг эрчимтэй нэмэгдүүлж, гадаад хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад хадгалагдахаар байгаа тул инфляц Төв банкны зорилтот интервалын орчимд тогтворжих хугацаа хойшлов. Монгол Улсын хувьд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнөөс дотоодын шатахууны үнэ нэмэгдсэн бол хилийн хязгаарлалт, нийлүүлэлтийн доголдол үргэлжилж, гадаад инфляц болон тээврийн зардал нэмэгдсэн нь импортын бараа болон хүнсний үнэ хурдтай өсөхөд нөлөөллөө.

Инфляц өмнөх оны 4 дүгээр улирлаас өсөлт нь хурдсаж 2022 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 16.1 хувь, Улаанбаатар хотод 16.9 хувьд хүрсэн ба үүний дийлэнх хэсгийг шатахуун, хүнс болон импортын барааны үнийн өсөлт бүрдүүлэв (Зураг 4.7).

Энэхүү үүсээд буй нийлүүлэлтийн хязгаарлалт, зардлын шинжтэйгээр эрчимжсэн инфляцын эсрэг ихэнх орны төв банк бодлогын хүүгээ өсгөж, бодлогын төлөвөө хатууруулах арга хэмжээг авч эхэллээ.


Мөн БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын нөлөөгөөр хилийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдмал хэвээр байгаа нь гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийг алдагдлыг тэлж валютын ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэв. Гадаад хүчин зүйлс, геополитикийн сөрөг нөлөө үргэлжилж байгаагаас инфляцын хүлээлт нэмэгдэх, хилийн хязгаарлалтаас шалтгаалан нүүрсний экспорт буурч, гадаад зах зээл дээрх үнийн өсөлттэй холбоотойгоор импорт нэмэгдэж, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал өсөж байна. Улмаар ханш сулрах дарамт нэмэгдэж, 2022 оны I улиралд төгрөгийн ам.доллартой харьцах ханш өмнөх улирлаас 3.48 хувиар, II улиралд өмнөх улирлаас 6.30 хувиар тус тус суларч, оны эхнээс нийт 9.99 хувиар сулав. (Зураг 4.8).

Зураг 4.7. Инфляц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.8. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Эцсийн хугацаа 2022.06 сар

Ийнхүү эдийн засгийн өсөлт саарсан, инфляц нэмэгдсэн, төгрөгийн ханш сулрах дарамт өндөр байгаа одоогийн нөхцөлд мөнгөний бодлогоор тохиргоо хийж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогын орон зай хязгаарлагдаж байгаа тул **мөнгөний бодлогыг хатууруулах төлөвт шилжиж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:**

1. Мөнгөний бодлогын хороо инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хангах, гадаад суурь хүү өсөж буй орчинд төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор 2022 оны 1 дүгээр сараас эхлэн бодлогын хүүг шат дараатайгаар нэмэгдүүлээд байна. Тухайлбал бодлогын хүүг 2022 оны 1, 3, 6 дугаар саруудад 0.5, 2.5, 1.0 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж 10 хувьд хүргэлээ.

2. Түүнчлэн 2022 оны 1 дүгээр сард (i) төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 8 хувьд хүргэх; (ii) уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох үрт хугацаат репо арилжааны санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх шийдвэр гаргав.

Цар тахал эхэлснээс хойшхи 2 жил гаруйн хугацаанд Төв банкнаас авч хэрэгжүүлсэн санхүүгийн зохицуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн арга хэмжээнүүдийг дуусгавар болгов. Үүнээс шалтгаалан санхүүгийн нөхцөл чангарч байна.

Түүнчлэн, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанкнаас валютын захад оролцож байна.

Монголбанкнаас богино хугацааны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцон ажилладаг бөгөөд энэ хүрээнд Монголбанк 2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 1,593.2 сая ам.долларыг худалдан авч, гадаад валютын дуудлага худалдаа болон цахим талбараар нийт 3,387.2 сая ам.долларыг дотоодын валютын захад нийлүүлэв. Ингэснээр Монголбанк цэвэр дүнгээр 1,794.0 сая ам.долларыг валютын захад нийлүүлээд байна.

4.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Дэлхийн улс орнуудад, ялангуяа хөгжиж буй эдийн засагтай орнуудад, санхүүгийн технологи (финтек)-д суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон цахим мөнгөний хэрэглээ улам бүр нэмэгдэж байна. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх, хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, финтекийн салбарын хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, оновчтой зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2022 оны 5 сард Улсын Их Хуралд өргөн барилаа. Түүнчлэн СЗХ-ноос даатгалын салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх, даатгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх зорилго бүхий даатгалын багц хуулийн төсөл болон “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулаад байна.

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллөөс шалтгаалан санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах чиглэлд СЗХ-ноос “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж,

зарцуулах журам”-д 2020-2021 онд нийт 3 удаа өөрчлөлт оруулж, зээлийн ангиллын хугацаанд өөрчлөлт оруулсан. 2022 оны 1 дүгээр сард СЗХ-ны ээлжит хуралдаанаар холбогдох журамд дахин өөрчлөлт оруулан, актив ангиллын хугацааг үе шаттайгаар буюу 30 хоногоор бууруулаад байна. Түүнчлэн, СЗХ-ноос тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлээгүй, эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэйд тооцогдож буй хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг тасралтгүй авч байна. Тухайлбал, 2020 онд 26 ХЗХ, 2021 онд 40 ХЗХ, 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 14 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Ингэснээр салбарт учирч болзошгүй эрсдэл хүндрэлийг урьдчилан сэргийлэх, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн 3 давхаргат хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлэх суурь хангагдах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж, зээлийн хоршоодыг чадавхжуулах замаар мэргэжлийн санхүүгийн байгууллага болгон хөгжүүлж, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг ач холбогдолтой юм.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна. Уг хуулийн 17 дугаар зүйлд “Шилжилтийн үеийн зохицуулалт”-ын дагуу 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд

аливаа компанийг Санхүү зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй байх, хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан этгээд дөрвөн сарын хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор СЗХ-нд бүртгүүлэхээр заасан. “Шилжилтийн үеийн зохицуулалт”-тай холбогдуулан СЗХ-ноос нэр бүхий журмуудыг баталж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх үйл ажиллагааг 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлээд байна. Холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагууд зөрчигдөх, хороонд бүртгэлгүй этгээд шилжилтийн үеийн зохицуулалтыг зөрчин арилжаа зохион байгуулах, виртуал хөрөнгийг хувьцаа мэтээр нийтэд сурталчилах зэрэг хууль бус үйл ажиллагааг илрүүлж, нэр бүхий 1 хуулийн этгээдэд мэдэгдэл, 2 хуулийн этгээдэд улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан.